

2017

Зохиолч : Е. Bygon Anderson

Орчуулсан : А. Чинбат (A. Chinbat)

Хянасан: Д. Цэнд-Аюуш (D. Tsend-Ayush) / Х. Наранчимэг
(Kh. Naranchimeg) / Г. Цэвэлмаа (G. Tsevelmaa)

Эмхэтгэсэн : Нэгдсэн Методист Чуулган(УМС)

Хэвлэсэн газар : Монгол дахь Нэгдсэн Методист Чуулган

Хаяг : Чингэлтэй дүүрэг 11-р хороо Дэнжийн 1000-ын гудамж
24 тоот байр.

[www. UMCdiscipleship.org](http://www.UMCdiscipleship.org)

Тусгай тайлбар гараагүй тохиолдолд библийн эшлэлийг The New Revised Standart Version ашигласан. /2013 оны монгол библийн орчуулгыг ашиглав/ Англи хэл дээрх библийг ашиглах бүрэн эрхийг 1989 онд The National Council of the Churches of Christ Христэч боловсролын байгууллага эзэмшсэн. Тус номыг зөвшөөрөлгүй хувиран ашиглахыг хориглоно.

Нэгдсэн методист чуулганы “Ариун Зоогийн утга учир” бүрэн эрхийг “Discipleship Resources” эзэмшинэ. Тус номыг зөвшөөрөлгүй хэвлэх эсвэл цахимаар ашиглахыг хориглоно. Гэхдээ дипломын ажил болон дүгнэлтэнд ашиглаж болно. Зохиогчийн эрхтэй холбоотой зөвшөөрлийг jcrowe@umcdiscipleship.org холбогдон авна уу.

ГАРЧИГ

Оршил	4
Библийн нотолгоо	5
Ариун Зоогийн нэршлүүд	7
Үг ба Зоогийн ширээ.....	10
Агуу талархал	12
Агуу талархлын залбиралтай холбоотой асуултууд	15
Ямар үйл явдал болдог вэ?	17
Христийн бодит оршихуй	19
Хэн Ариун Зоогийг хүртэж болох вэ?	21
Хэн Ариун Зоогийг хүртэж болох тухай асуултууд	23
Хэн Ариун зоогийг хүртэх эрхтэй вэ?	24
Хэдэн удаа?	26
Давтамж ба цаг үеийн талаарх асуудал	28
Ариун Зоогийг барих хэлбэрүүд	29
Бусад асуултууд.....	32
Ариун ёслол гүйцэтгэл	33
Зоогийг удирдах ба хуваалцах	37
Талх ба дарсны хэрэглээ.....	42
Ариун Зоогийн сүнслэг чанар.....	45
Ном зүй.....	46

ОРШИЛ

Эзэний Зоогийн ширээн дэх баярт уригдана гэдэг агуу хийгээд ариун хэрэг. Зарим хүмүүсийн хувьд тэрхүү зоогийн ширээнд уригдсан явдал нь тэдний амьдралд тохиолдож байсан ариун зүйлсийг сануулах эсвэл хувь хүний чуулгантай харилцах онцгой харилцаа, Бурханы хязгааргүй ивээлийг, харин өөр бусад хүмүүст чуулганы төгс бус бодит байдлыг ч санагдуулах нь бий. Тэр нь хэд хэдэн чуулган өөрийг нь баяртайгаар хүлээн аваагүйн дурсамж байх ба, мөн чуулган хоорондын, чуулганы хамт олны доторх, гэр бүл дэх гишүүд дунд шаардлагатай эвлэрэл ба ёс зүйгүй байдал мөн бүтэлгүйтэл юм. Эдгээр нөхцөл байдлууд нь бидэнд Ариун Зоогийн талаарх ойлголтоо нягтлан үзэхэд чиглүүлдэг.

Энэхүү гарын авлага нь Нэгдсэн Методист чуулганд хэрэгжүүлдэг Ариун Зоогийн ёслолын утга учир, ёслолын үйл явцыг товч танилцуулахын тулд хэвлэгдсэн. 2004 онд Нэгдсэн Методист чуулганы нэгдсэн хурлаар батлагдаад 2012 онд дахин батлагдсан “Энэ Ариун ер бусын байдал: Ариун Зоогийн талаарх Нэгдсэн Методист чуулганы ойлголт” (This Holy Mystery: A United Methodist Understanding of Holy Communion – цаашдаа ТНМ гэж товчилно) хэмээх номын агуулгад тулгуурлан тус номыг хэвлэлээ. Бид Ариун Зоогийн утга учрын тухайд тулгуур болсон төдийгүй нийтлэг хэд хэдэн асуултыг судлан үзнэ. Библи нь Ариун хүнс (holy meal) – ний талаар юуг хэлдэг вэ? Ариун Зоогтой холбоотой янз бүрийн нэршлүүдийн илэрхийлж буй зүйлс нь юу болох, эдгээр нэршлүүд нь Ариун Зоогийг ойлгоход бидэнд ямар хэрэгжүүлэлтийг бий болгох вэ? Ариун Зоогийн ёслол (Нэгдсэн Методист чуулганы магтуу ба мөргөлд эмхэтгэгдсэн Ариун Зоогийн асуулт, Word and Table in The United Methodist Hymnal) – ын суурь болон хэлбэр нь Ариун Зоогийн ойлголтонд ямар нөлөө үзүүлдэг вэ? Эзэний Зоогийн ширээн дэх агуу талархлын залбирал (The Prayer of Great Thanksgiving) гэж юу вэ? Чуулганы амьдралд мөн чуулганы амьдралын төлөөх Ариун Зоогийн үүрэг нь юу вэ? Ариун Зоогийг хэдэн удаагийн давтамжтайгаар үйлдэх вэ? Яагаад чуулган тус бүрийн үйлддэг Ариун Зоогт хэлбэрийн хувьд ийм олон ёслол байдаг вэ? Энэхүү гарын авлага нь дээрх утга агуулгатай холбоотой асуултаас гадна Ариун Зоогийн ёслолтой холбон байнга тавигддаг асуултаудад хариулах болно. Ялангуяа Ариун Зоогийг хэн удирдах талаар, Ариун Зоогт ашигладаг талх болон усан үзмийн дарсыг хэрхэн хэрэглэх тухай, өөрчлөгдөж байгаа дижитал чуулганы соёлд хэрхэн хандах талаарх асуултаудад хариулна.



БИБЛИЙН НОТОЛГОО

Библид гардаг олон түүх нь Ариун Зоогийг ойлгоход тус болдог. Есүс баривчлагдахынхаа өмнөх орой дээврийн өрөөнд дагалдагч нартайгаа барьсан сүүлчийн оройн зоогийн түүхийг бид байнга ашигладаг. (Матай 26:17-30, Марк 14:12-26, Лук 22:7-23). Сайнмэдээний номуудад Есүс урвалтыг мэдэрсэн өдрийнхөө орой хэрхэн талхыг гартаа барьж, ерөөн, хувааж дагалдагч нартаа өгөхдөө “Энэ бол Миний бие” хэмээн хэлснийг бичсэн байдаг. Зооглосныхоо дараагаар Есүс усан үзмийн дарсыг авч ерөөгөөд, дагалдагч нартаа өгөхдөө “Энэ бол нүглийн уучлалыг өгөхийн тулд олны төлөө урсах Миний гэрээний цус” гэж айлдсан (Матай 26:26-28).

Элч Паул 1Коринт 11:23-26 эшлэлд Ариун Зоогийн уламжлалыг дахин тайлбарлахдаа, энэ нь Эзэн Есүсээс аваад чуулган болон бидэнд дамжуулдаг уламжлалыг чуулганд сануулдаг.

Дээврийн өрөөнд зоогийн ширээнд Есүсийн айлдсан үгсийг “нэг бүрчлэн заасан хүүрнэл” (institution narrative) гэж хэлдэг. Эдгээр хүүрнэл/түүхүүд нь Ариун Зоог хэрхэн бий болсныг тайлбарлаж, Есүс энэхүү сүүлчийн зоогоо Өөрийг нь дурсан Өөрийнх нь нэрээр чуулганд үргэлжлүүлэн хийгээрэй хэмээн тушаасныг өгүүлдэг¹.

¹ This Holy Mystery : A United Methodist /understanding of Holy Communion (Nashville : General Board of Discipleship, 2004), Ариун ер бусын байдал : Ариун Зоогийн талаарх Нэгдсэн Методист Чуулганы ойлголт” – цаашдаа энэхүү номыг ТНМ хэмээн товчлох болно. р8-9

Хүүрнэлтэй холбоотой түүхүүд нь бүгд Өөрийгөө илэрхийлсэн Есүсийн золиос, үхэлтэй нүүр тулж байсан ч Ариун Эцэгтээ харуулсан итгэмжит байдал болон дагалдагч нарт үзүүлсэн Түүний байнгын анхаарал халамжийг чухалчилдаг. Дээгүүр Өнгөрөх баярын зоогийн зураглалаар харуулсан сүүлчийн зоог нь бидний анхаарлыг Дээгүүр Өнгөрөх баярын үйл явдлууд (Египетээс гарсан нь 12:1-28) хийгээд Есүсийн загалмайн үхэл хоёрын холбоонд төвлөрүүлдэг. Египетээс гарсан түүхээс харвал Израиль хүмүүсийн хаалганыхаа хатавчинд нялсан хурганы цус нь Бурханы хараал өөрсдийнх нь гэрт ирэхгүй байхын тулд байв. Үүний адилаар сүүлчийн оройн зоог ба Есүсийн загалмайн зовлонгийн тухай Сайнмэдээний бичээст өгүүлэхдээ Есүсийн цус нь хүмүүсийн гэм нүглийн талаарх Бурханы шүүлтээс аврах үүргийг гүйцэтгэдэг.

Ариун Зоогийн утга учрын талаарх ойлголтонд тусладаг бичээсүүд гэвэл зөвхөн эдгээрээр зогсохгүй. Олон түмнийг хооллосон тухай (Матай 14:13-21, Марк 6:30-44, 8:1-10, Лук 9:10-17, Иохан 6:1-13, 25-29) Есүс талхыг авч ерөөгөөд хуваан өгч буй зураглалууд нь бүгд дээврийн өрөөнд сүүлчийн зоог дээр үйлдсэн үйлдлүүдийн давтамж болохын хувьд уг хоёр зураглалын хооронд харилцан холбоо байдаг. Есүс олон түмнийг хооллосон тухай өгүүлдэг сайнмэдээний ном дахь бичээсүүдээр дамжуулан бид Есүс Өөрийг нь дагагсдыг хичнээн ихээр хайрлан халамжилж байсныг нь харах болно. Эдгээр түүхүүдээр дамжуулан бидний мэдэж болох зүйл бол Есүс сургаалаараа дамжуулан тэдний сүнслэг өлсгөлөнг дүүргэж өгснөөр барахгүй талхаар дамжуулан тэдний махан биеийн өлсгөлөнг ч шийдвэрлэж өгсөн гэсэн үг.

Иохан ном (Иохан 6:25-51) нь Бурхан цөлд байгаа хүмүүст идэх хүнсийг ханган өгч буй нь Есүсийн цаг үед анх удаагаа болж байгаа явдал биш, мөн сүүлчийнх ч биш гэдгийг бидэнд хэлж өгдөг. Иохан бидэнд Египетээс гарсан түүх болон Израилийн ард түмэн цөлийг гаталсан үеийн түүхийг (Египетээс гарсан нь 16:1-17) санагдуулдаг. Израилийн ард түмэн Бурханыг сорьж байхад ч гэсэн (Дуулал 95:9) Бурхан цөлд буй Израилийн ард түмэнд Манна болон бөднө шувууг бэлэг болгон өгч хүнсээр хангаж байсан.

Есүс талх авч ерөөгөөд хуваан өгч буй зураглал болон үүний адил бусад хүүрнэлүүд нь Есүс үхлээс амилсныхаа дараа дагалдагч нартаа үзэгдсэн хүүрнэлүүдэд ч дахин дурдагддаг. Лук 24:13-35 эшлэлд Эммау орох замд хоёр дагалдагчтайгаа уулзаж буй тухай өгүүлдэг. Тэд замд хамт яваа Есүсийг таньж чадалгүй, өөрсөдтэй нь хамт хооллохыг хүсэн

Есүсийг урьдаг. Есүс талх авч ерөөгөөд, хувааж дагалдагчдад өгөхөд тэдний нүд нээгдэн Есүсийг таньсан. Үүнтэй төстэйгээр Есүс үхлээс амилсныхаа дараагаар далайн хөвөөн дэх дагалдагчид дээрээ ирэн тэдэнд зориулан хүнсийг бэлдэж өгөх үед тэд Есүсийг таньсан түүхийг Иохан тэмдэглэн бичсэн (Иохан 21:4-14).

Бид Үйлс 2:42-47 эшлэлээс анхны чуулган дахь элч нарын сургаал болон итгэгч нарын нөхөрлөл мөн Ариун Зоог болон залбиралаар дамжуулан Есүсийг хэрхэн дурсан санаж байгааг харж болно. Эдгээр үйлдлүүд нь анхны үеийн итгэгч нарыг онцлох зүйлс нь болсон.

Бид эдгээр түүхүүдээр дамжуулан итгэлийн хамт олныг халамжилж тэдэнтэй хамт байдаг Есүсийн түүхийг сонсдог. Матай, Марк, Лукын дамжуулсан сүүлийн оройн зоогийн түүхээс Есүс бидний гэм нүглийн улмаас золиосны Хурга (Дээгүүр Өнгөрөх баярын түүх) болсон билээ. Амийн талхны тухай Есүсийн сургаал нь бидэнд Египетээс гарсан түүхийг санагдуулдаг. Есүсийн энэхүү үйлдэл нь цөлд ч гэсэн хүмүүсийг хүнсээр хангадаг. Бурханы дуусашгүй халамжтай холбогдсон байдаг. Есүс үхлээс амилсныхаа дараа ч дагалдагчид болон итгэлийн хамт олондоо ирээд ийм халамжийг үзүүлсэн. Үйлс номоос харвал анхны чуулганы итгэгчид өдөр бүр цуглахдаа Есүсийн Өөрийнх нь эргэн тойронд цугларсан янз бүрийн давхрагын хүмүүстэй хүнсээ хуваалцаж тэдэнд өгсөн золиос ба нөхөрлөл, халамжийг дурсан санаж байлаа.

АРИУН ЗООГИЙН НЭРШЛҮҮД

Чуулганууд Ариун Хүнс (the holy meal) – ийг Ариун Идээ (Eucharist), Эзэний Зоог (Lord's Supper), Ариун Зоог (Holy Communion) гэх мэтчилэн олон янзаар нэрийддэг. Үүнээс гадна өөр олон нэршлүүд байдаг ч, Нэгдсэн Методист чуулган нь дээрх гурван нэрийг хамгийн ихээр ашигладаг. Нэршил бүр нь Шинэ Гэрээний нотолгоо болон анхны чуулганы итгэлийн амьдралд тулгуурласан байдаг.

Хэд хэдэн урсгал чиглэлд Ариун Хүнсийг Ариун Ёслол буюу зан үйл (sacrament) гэдэг бол өөр зарим урсгал чиглэлд ёслол (ordinance) гэх нь ч бий.

Нэгдсэн Методист чуулганы итгэгч гишүүний хувьд бид Ариун

Зоогийг Ариун Ёслол гэж ойлгодог. Ариун Зоог (мөн Баптисм) нь Бурхан бидэнтэй уулзаж, бидний дотор ажиллаж, энэрэл хайраараа биднийг тэтгэн тэнхрүүлдэг арга зам билээ. Ариун Ёслол нь “ивээлийн нэгэн хэлбэрийн илэрхийлэл болохын сацуу бидэнд хандсан Бурханы сайн хүсэл юм.” Ариун Ёслолоор дамжуулан “Бурхан бидний дотор үл харагдахуйцаар ажиллаж, бидний итгэлийг цог золбоотой болгон, хүчирхэгжүүлж, батжуулдаг.”

Ариун Ёслол гэх үг нь андгай тангараг эсвэл амлалтыг илэрхийлдэг латин үгээс үүдэлтэй. Энэ тохиолдолд андгай тангараг нь Бурхан бидний амьдралд үргэлжид хамтдаа байна гэсэн Түүний амлалтыг илэрхийлнэ. Ариун Зоогийн ариун ёслол нь чуулганд хандсан Бурханы энэхүү амлалтыг бэлгэддэг ба мөн энэ дэлхийд хандсан Бурханы хайрын яруу сайхныг харуулдаг.

Эсрэгээрээ ёслол (ordinance) нь тушаал бөгөөд зарчим, хууль юм. Бид Ариун Зоогийг ёслол гэж үзэх үед, бид Есүсийн Өөрийг нь дурсан “үүнийг үйлд” гэж айлдсан тушаалыг биелүүлэх үүднээс Ариун Зоогт оролцож байна гэж хэлж байгаа юм.

Ариун Зоогийг ариун ёслолоор үзэх нь талх ба усан үзмийн дарсаар дамжуулан ажиллах Бурханы гайхамшигт ажлыг чухалчилж буй хэрэг. Энэ нь Бурханы хайр бол ивээлт бэлэг болохын хувьд бидэнд ирэх арга гэж үзнэ. Ариун Зоогийг ариун ёслолоор үзэх нь бидний үүрэг даалгавар, үйлдэлд эхлэлийн цэг болно. Ийм ойлголт нь Бурханы ивээлт оршихуй ба үр дүнгээр биелэгддэг тушаалд нь хариулж буй бидний үүрэг даалгаврыг чухалчилдаг.

Нэгдсэн Методист чуулганы итгэгчийнхээ хувьд бид өөрсдийн амьдралд оршин байгаа Бурханы ивээлт ажлыг юуны түрүүнд тавьдаг учраас Ариун Зоог бүхий ариун ёслолын онцлогийг эхэнд тавина Бидний дуулгавар болон үйлдэл нь бидний амьдралаар дамжуулан ажилладаг Бурханд хариулж буй хариу үйлдэл болно.

Ариун идээ (Eucharist) гэх үг нь “Талархал өргөх” гэсэн грек үгээс үүдэлтэй. Олон түмнийг хооллосон болон дээврийн өрөөнд сүүлчийн оройн зоог барьсан түүхүүдэд Есүсийн үйлдэл нь талхыг авч ерөөгөөд, хуваан өгч байгаагаар дүрслэгддэг. Матай 26:26-27, Марк 14:22-23 эшлэлд Есүс талхыг ерөөгөөд, дарсыг авч талархан залбирдаг. Талх ба дарс бүхий хүнсийг Ариун идээ (Eucharist) гэж нэрлэснээрээ бид Есүс талх ба дарсыг хуваалцсанаар энэ дэлхий рүү чиглэсэн Бурханы авралд талархал өргөсөн гэдгийг санадаг. Мөн түүнчлэн энэхүү үг нь бид

Эзэний зоогийн ширээнээ талх ба дарсыг хуваалцахдаа өргөдөг залбирал дундах магтаал ба талархлыг чухалчилдаг.

Бид Эзэний Зоог (Lord's Supper) хэмээх үгийг хэрэглэвэл, энэ нь элч Паулын 1Коринт 11-р бүлэгт өгүүлж буй илэрхийлэлд түшиглэж буй хэрэг юм. Уг эшлэлд Паул, Эзэний Зоогийн үлдэгдлийн талаарх чуулганы үүргийг дурдсан. Коринт чуулганд итгэгчдийн дунд ялгаварлал бий болж, тэгш бус байдал дэлгэрсэн байлаа. Чуулганы итгэгчдээс зарим нь чуулгандаа түрүүлж ирээд идэж ууснаар дараа нь ирсэн итгэгчдэд идэх зүйл үлддэггүй байв (1Коринт 11:17-22). Паулын үзсэнээр ийм үйлдэл нь Христийн бие болох чуулган бүгд хамтдаа оролцох учиртай Эзэний Зоогийн уг санааг зөрчиж буй хэрэг байлаа.



Ариун Зоог нь чуулганд харьяалагддаг зүйл гэж итгэх нь үнэмшилтэй харагддаг. Харин Коринт чуулганд хандсан Паулын сануулгаас харвал Ариун Зоог нь бусад хүмүүсийг урин дууддаг бидний Ариун Зоог бус бид өөрсдөө урилгыг нь хүлээн авсан Христийн Зоог, өөрөөр хэлбэл Эзэний Зоог юм. Дахин хэлбэл, бид гол эзэн нь биш Есүс Христ Өөрөө эзэн нь юм. Христ биднийг Өөрийнхөө зоогт урьснаар бид Түүнтэй хамт нөхөрлөж, мөн бусад хүмүүстэй ч Түүний зоогийн ширээнээ хамтдаа нөхөрлөдөг.

Ариун хүнсний талаарх гурав дахь нийтлэг нэршил нь Ариун Зоог (Holy Communion) юм. Энэхүү нэршил нь бид Эзэний зоогийн ширээнээ тойрон суухдаа Христтэй болон бусад хүмүүстэй нэгддэг (commune) гэдгийг илэрхийлдэг. Паул Коринтын чуулганд хандан хэлэхдээ Бурхантай нэгдэнэ гэдэг нь итгэгчид хоорондын харилцан нэгдлийг эн тэргүүнд тавих явдал юм гэдгийг ухааруулахаар өдөөн бичсэн. Коринтын итгэгчид Эзэний зоогийн ширээнээ тойрон суух итгэлийн хамт олны дунд үнэхээр Христийн бие оршдог гэдгийг ухаарч чадаагүй байлаа. Итгэлийн хамт олныхоо хувьд хамтдаа талх ба дарсыг хуваалцахдаа бие биенээ хайрын харилцаа уруу хөтлөн Есүс Христийн дотор Бурхантай ч мөн харилцаа тогтоодог. Ариун Зоогоор дамжуулан бид Бурханд талархал өргөж Эзэний Зоогийг хамтдаа хуваалцсанаараа

Бурханыг хайрлах хайр болон хөршөө хайрлах хайрын талаарх агуу тушаалууд (great commandments) – ыг хэрэгжүүлэх арга замыг олж авдаг.

Бид Ариун хүнсийг Ариун идээ (Eucharist) гэж дуудвал, Есүс зоог барихаар дагалдагч нараа дуудсаныхаа дараа Бурханд өргөсөн талархлыг санагдуулах болно. Ариун Зоогоор дамжуулан бид Бурханд магтаал, талархлыг өргөдөг. Бид Христийн амьдрал хийгээд үхэл, мөн амилалтыг нь бэлгэддэг талх ба дарсны төлөө талархах төдийгүй, ертөнцийг аврахын тулд Бурханы хэдийн хийсэн, мөн одоо ч хийсээр байгаа бүх зүйлд талархлыг өргөдөг.

Бид Ариун хүнсийг Эзэний Зоог (Lord's Supper) гэж дуудвал, биднийг уриад амийн талх ба авралын дарсыг соёрхдог Нэгэн дээр хараагаа чиглүүлэх болно.

Бид Ариун хүнсийг Ариун Зоог (Holy Communion) гэж дуудвал тэрхүү зоогийн ширээнээ явагддаг цугларалтынхаа үр дүнд бид анхаарлаа тавих болно. Бид Ариун Зоогоор дамжуулан Бурхан болон хөрштэйгөө харилцах харилцааг тогтоож мөн тэрхүү харилцаагаа хадгалдаг.

ҮГ БА ЗООГИЙН ШИРЭЭ

Ариун Зоогийн ёслолын бүтцийг Ариун Зоогийн (Word and Table) ёслолуудаас харж болно. Ёслолын үндсэн хэлбэрийн хувьд Лук 24:13-25-д гардаг Эммаугийн түүхээс харж болно. Эммау тосгонд дагалдагчид амилсан Есүстэй уулздаг. Есүс тэдэнд Библийг тайлбарлан өгч тэдэнтэй хамт оройн зоог барьдаг. Есүс талх авч ерөөгөөд хуваан өгөхөд дагалдагчдын нүд нээгдэж Есүсийг таньсан. Тэгээд дагалдагчид Иерусалим уруу буцан Есүсийн амилсан тухай гайхалтай мэдээг тунхагласан.

Энэ мэтчилэн тунхаглал ба хариу үйлдэл (үг), бас талархал болон нөхөрлөл (зоогийн ширээ) – өөс бүрдсэн үндсэн бүрдэл нь өнөөдөр ч Нэгдсэн Методист чуулганы мөргөлийн ерөнхий хэлбэрийг бий болгож байна. Библийн уншлага ба номлол дунд тунхаглагддаг үг нь Эзэний зоогийн ширээнээ тунхаглагдсан үгтэй адил бөгөөд, Эзэний зоогийн ширээнээ талх авч хуваахад тунхаглагдсан үг нь Библийн уншлага болон номлолын явцад тунхаглагддаг үгтэй адил гэж үздэг. Өөрөөр

хэлбэл, үүн шиг мөргөлийн бүрдэл нь Ариун Зоогийн ёслолтой мөн чанар нэг болохыг илэрхийлдэг. Ийм бүрдлийг агуулж буй мөргөлийн багтаамж нь бусад чуулганд мөргөлийн маш том, олон талт шинжийг бий болгох ба мөргөлтэй холбоотой үндсэн хэлбэрийг харуулдаг.

Үүнчлэн Ариун Зоогийн ёслолын үндсэн бүрдэл дотор, зоогийн ширээний ёслолтой холбоотой хэсэг нь Есүсийн дагалдагчидтайгаа хамтдаа зоогийг хуваалцсан тэрхүү түүхэн хүүрнэлийн адилаар 4 зүйлийг тусган харуулдаг: Есүс 1.Талх ба дарсыг аваад, 2.Ерөөгөөд эсвэл талархан залбираад, 3.Талхыг хувааж, дарсыг хундагалаад, 4.Талх ба дарсыг дагалдагчиддаа өгсөн.

Олон зууны туршид чуулган нь “үүнийг үйлд” гэсэн Есүсийн тушаал болох талх ба дарсыг авч хуваалцах төдийгүй өнөөг хүртэл чуулган нь Бурханы бүтээл ба аврал мөн ариусгалаар дамжуулан үүнийг хүртсээр ирсэн бөгөөд эдүгээ ч гэсэн хүртсээр буй зүйлсийнхээ тухайд Бурханыг ерөөх юмуу Бурханд талархал өргөх явдлыг агуулсан хэмээн ойлгодог.

Талх ба дарсыг авч ерөөгөөд (эсвэл талархаад) бид Бурханы бидэнд өгсөн авьяас чадварыг Есүс Христийн дотор хуваалцахаар өөрийгөө болоод зоогийн ширээг бэлтгэдэг. Энэ нь бид өдөр тутмынхаа хоолондоо зоогийн ширээг бэлддэг шиг энгийн л зүйл юм. Түүнчлэн энэхүү бэлтгэлээр дамжуулан талх ба дарсыг хамтдаа хуваалцахдаа Христ бидэнтэй хамт байгаа гэдгийг ухаарахуйцаар өөрсдийнхөө сэтгэл хийгээд бодол санааг ч бэлтгэдэг.

Талхыг авч хуваалцахдаа (хуваалцал) бид харилцан хуваалцахын тулд бодитоор талхыг хуваах хэрэгтэй. Ингэхдээ бид Есүс талхыг авч хуваахдаа энэ ертөнцийн төлөө Өөрийнхөө биеийг хуваан өгч буйгаар төсөөлж, мөн одоо ч гэсэн энэ ертөнцийг болон биднийг эдгээхийн төлөө Өөрийнхөө эмтэлсэн биеийг өгсөөр байгааг дурсан санадаг.

Талархлаа хуваалцахын тулд бид зоогийн ширээг засаад хамт олноороо талх ба дарсыг бие биетэйгээ хуваалцахаар бэлддэг бодит үйлчлэлүүдийг хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн бид, бидний төлөө бидэнтэй хамт одоо ч үйлдсээр байгаа Бурханы ажлуудын талаар талархлаа өргөдөг теологийн гүн утгатай ажлуудыг ч хийдэг байх хэрэгтэй. Теологийн гүн утгыг агуулсан ажил гэдэг нь Бурхан ба би, бас би ба бусадтай харилцах харилцан нөхөрлөл руу биднийг дотносуулан хөтөлдөг. Бурхан энэхүү нөхөрлөлд бидэнд буй өдөр тутмынхаа хүнсээ өөрсдийн дунд буй хамгийн сул дорой нэгэнтэйгээ хуваалцахыг ятгадаг.



АГУУ ТАЛАРХАЛ

Ариун Зоогийн ёслол дахь талархлын залбирлыг Агуу Талархал (the Great Thanksgiving) буюу Ариун Зоогийн залбирал (Eucharistic Prayer) гэдэг.

Агуу Талархал нь Бурханыг Ариун Гурвалаар ойлгодог бидний ойлголтыг тусгадаг. Энэхүү талархлын залбирал нь бүгд Ариун Эцэгт хандсан талархал юм. Энэхүү талархлын агуулга нь Есүс Христээр дамжуулан үйлдсэн Ариун Эцэгийн ажлыг дурсах бөгөөд Эзэний бэлэг болох талх ба дарс, мөн Эзэний зоогийн ширээнээ цугласан бүхий л итгэгчдийн дээр Ариун Сүнс дүүрэн ирэхийг урьсан хүсэлт багтдаг.

Ариун Гурвалын хэлбэр нь чуулган Бурханд талархаж, Есүс Христийг дурсан санаж, Ариун Сүнсний оршихуйг урин хүсэх боломжийг өгдөг. Ингэхдээ Агуу Талархал нь Христ ба бидний хооронд, мөн итгэгчдийн хооронд, бүр цаашлаад хүн ба ертөнцийн хооронд байх ёстой дотно нөхөрлөлийн “мессеж”-ийг өгдөг. Түүнчлэн, Агуу Талархал нь Ариун хүнсээр дамжуулан ирээдүйд Христийн тэнгэр дэх найран дээр бидний хүлээн авах зүйлийг урьдаас мэдүүлж буй гэдгийг сануулдаг.

Агуу Талархал нь ерөнхий байдлаараа 5 хэсэгт хуваагдана:

1. Нээлтийн уншлага²
2. Бурханд талархах
3. Есүс Христийг дурсан санах
4. Ариун Сүнсний оршихуйг урин хүсэх
5. Төгсгөлийн хүндэтгэлийн магтаал

НЭЭЛТИЙН БИБЛИ УНШЛАГА

Агуу Талархал нь пастор/хоньчин ба итгэгчдийн харилцан уншлагаар эхэлнэ:

Бурхан та бүхэнтэй хамт байх болтугай.

Бурхан бас тантай хамт байх болтугай.

Өөрсдийнхөө зүрх сэтгэлийг Бурханд өргөнө үү.

Өөрсдийнхөө зүрх сэтгэлийг Бурханд өргөж байна.

Эзэн бидний Бурханд талархлыг өргөө.

Талархал ба магтаалыг өргөх нь зохистой.

Энэхүү харилцан уншлага нь хэдэн зүйлийг хэрэгжүүлдэг. Юуны түрүүнд пастор ба бүх итгэгчид харилцан мэндэлснээр эхэлнэ. Энэ үед Эзэн бидний хүн бүртэй хамт байж, цаашлаад бид Эзэний зоогийн ширээнээ цуглахад биднийг ерөөгөөсөй хэмээн хүсэн урьдаг. Дараа нь бидний зүрх сэтгэлийг бэлдэж өгөх эшлэлийг уншина. Бид Бурханд бүрэн төвлөрч Түүнийг хайрлахад өөрсдийн зүрх сэтгэл бодол санааг өргөнө. Библи харилцан уншлагын төгсгөл хэсэг нь чухал байдаг. Учир нь пастораар өргөгдөж буй талархал нь зөвхөн түүнийх бус бусад бүх итгэгчдийн өргөж буй талархал учраас тэр юм.

ТАЛАРХЛЫН ИЛЭРХИЙЛЭЛ

Агуу талархлын хоёр дахь хэсэг нь талархлын хамтаар Ариун Эцэгийг маш тодорхойгоор дурьддаг. Энэ хэсэгт бид түүхээр дамжуулан илэрхийлэгдсэн Бурханы авралыг санадаг. Тэр дундаа бид Бурханы бүтээлийн тухай дурсан санаж, Бурханы амлалт ба хүний үнэнч бус байдал байсаар байхад хүмүүсийг харамгүйгээр хайрласаар байдаг хайрыг нь дурсан санадаг. Бурхан тэднийг цөллөгдөн боолчлогдож

² Мөргөл нээж Пастор болон итгэгч нар тухайн өдрийн Эзэний үгтэй холбоотой библийн үгийг уншдаг.

байхад авран чөлөөлсөн, эш үзүүлэгчдийг илгээж үгээрээ Эзэн Өөрийн ард түмнээ хамгаалсан. Энэ хэсгийг бүх итгэгчид дараах байдлаар өчил эсвэл магтуугаар өндөрлөдөг: “Ариун ариун ариун Эзэн, хүч чадлын Бурхан...” Энэхүү энгийн магтуу нь Исаиа 6 дугаар бүлэгт Бурханы оршихуйн эргэн тойронд тэнгэр элч нарын дуулдаг магтуу юм. Энэ нь мөн Дуулал 118:26-д гардаг ялалтын магтаалын агуулга бөгөөд, энэхүү ялалтын магтан дуу нь Иерусалимд орж ирж буй Есүсийг угтан олон түмний дуулсан магтан дуу (Матай 21:9, Марк 11:9) билээ. Бидний магтаал нь энэ мэтчилэн тэнгэр элч нар ба олон түмний өргөсөн магтаалтай нэгддэг.

ДУРСАМЖ

Агуу талархлын гурав дахь хэсэг нь Есүсийн онцгой үйлчлэл ба ажилд төвлөрч, үгийг (institution narrative) агуулдаг. Энэ хэсэгт чуулган нь Есүсийн тунхагласан чөлөөлөлт ба эрх чөлөө эдгээлтийг дурсан санадаг (энэ залбирал нь Исаиа 61:1 ба Лук 4:18-19 дэх агуулгыг илэрхийлсэн). Бид Есүсийн зовлон ба үхэл, амилалт дотор гэм нүгэл хийгээд үхлийн хүчээс чөлөөлөгдсөн, Бурханы дотор амийн эрх чөлөөг олж авснаа дурсан санадаг. Эдгээр сэдвүүд нь түүхийн хувьд Нэгдсэн Методист чуулган энэ дэлхий рүү чиглэсэн авралын зард үнэнч зүтгэснийг тусган харуулдаг. Заримдаа энэ хэсэг нь тогтсон сэдвээс хальж чуулганы хуанлигаас шалтгаалан онцгой сэдэв болон онцлох зүйлсийг тусгадаг. Жишээлбэл, Христмасын баярын үед малын гэжээлийн тэвшинд тарчигхан нөхцөлд мэндэлсэн Есүсийг онцолж, зовлонгийн өдрүүдийн туршид Есүс цөлд 40 хоногийг өнгөрөөснийг онцолдог. Есүс Христээр дамжуулсан Бурханы хүчирхэг түүх хийгээд бидний төлөө Христ нас барсныг дурсан санаснаар, бид өөрсдийгөө Христтэй нэгтгэж магтаал ба талархал дотор өөрсдийгөө Түүнд өргөдөг. Энэ хэсэг нь итгэгч нарын энгийн хариу магтаал эсвэл хүндэтгэлийн магтаалаар өндөрлөх бөгөөд, бид “Христ нас барсан. Христ үхлээс амилсан. Христ дахин ирнэ.” гэсэн Христитгэгчийнхээ итгэл найдвараа энэ хэсэгт өчнө.

ГУЙЛТ

Агуу талархлын дөрөв дэх хэсэг нь Ариун Сүнсний оршихуй болон хүч нь талх ба дарс мөн Эзэний зоогийн ширээнээ цугласан итгэгчдийн дээр дүүрэн ирэхийг урих явдал юм. Ариун Сүнсний хүч дотор талх ба дарс нь бидний төлөөх Христийн бие ба цус болдог. Өөрөөр хэлбэл, бид ертөнцийн төлөөх Христийн бие болно гэсэн үг. Бурханы хайр хийгээд хүч дотор Христтэй болон итгэгчидтэйгээ нэгдмэл болсон бид бүх дэлхийд Бурханы хайрыг мэдүүлэх үүрэг хариуцлагыг хүлээн авдаг.

ХҮНДЭТГЭЛИЙН МАГТААЛ

Агуу Талархлын сүүлчийн буюу тав дахь хэсэг нь хаалтын хүндэтгэлийн магтаал эсвэл магтуу болохын хувьд, агуу талархал нь эхэлсэн шигээ өндөрлөдөг. Залбирал нь Ариун Эцэг, Ариун Хүү, Ариун Сүнс болох Ариун Гурвал Бурханд талархал болон магтаалыг өргөдөг. Дараа нь Бурханд хүндэтгэл, алдар, магтаалыг өргөн барьснаар залбирал дуусна. Энэ бүх залбирлын төгсгөлд бүх итгэгчид чангаар “Амен” гэж хариулна. Ингэснээр бидний өргөсөн бүх залбирал үнэхээр бидний залбирал юм гэдгийг баталгаажуулна. “Амен” нь “Тийм ээ, энэ нь бидний залбирал” гэх итгэгч нарын өчил юм.

АГУУ ТАЛАРХЛЫН ЗАЛБИРАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД

Асуулт: Мөргөлийн явцад Ариун Зоогийн асуултын хариултыг хүн бүрээс авна гэвэл цаг хүрэлцэхгүй. Ийм нөхцөлд ашиглаж болох хураангуйлсан Агуу Талархлын асуулт хариулт нь ямар вэ?

Хариулт: Бидний ихэнх нь тийм байдаг шиг пасторууд ч мөн ажлаа илүү хурдан, илүү үр дүнтэй хийх хэрэгтэй гэсэн

дарамтыг тээж явдаг байх. Гэвч “Ер бусын зүйлс дотор амьдрах нь” (Living into the Mystery) гэх номд дурдсанаар, цаг хугацаанаас илүү эрхэм чухал зүйл бол Ариун Зоогийн ёслолыг ивээлтэйгээр мөн ёслол төгөлдөр явуулах явдал юм. “Нэгдсэн Методист чуулганы магтуу болон мөргөл”-д байдаг Ариун Зоогийн ёслолын асуулт хариулт III – ыг харвал залбирлын уншлагын оронд пасторууд нь өөрсдөө залбирхаар тогтсон байдаг (гэсэн хэдий ч Ариун Зоогийн ёслолын асуулт хариулт III нь хураангуй биш юм. Энд пасторын хийх залбирлын нээлт ба итгэгчдийн хариултыг багтааж чадахуйц энгийн тайлбар бүхий агуулгыг гол хэсэгт нь оруулсан). Ёслолыг удирдаж байгаа пастор нь залбирахдаа богинохон залбирч бас болно. Гэхдээ дараах агуулгыг заавал багтаан залбирах хэрэгтэй. “нээлтийн библи уншлага, Бурханы аугаа бүтээл ба Есүс Христээр боломжтой болгосон авралд талархах талархал, Ариун Зоогийн хуваарилалт, Ариун Сүнсний оршихуйн гуйлт, Ариун Гурвал Бурханд хандсан хаалтын магтуу.” Харин “Нэгдсэн Методист чуулганы магтуу ба мөргөл”-д бичигдсэн мөргөлийн бичвэрүүдэд (The Worship Resources of The United Methodist Hymnal) Hoyt Hickman– ны зааснаар бол Ариун Зоогийн асуулт хариулт III ыг ашиглах гэж буй пасторууд нь “Агуу Талархлын агуулгыг гүн гүнзгий тунгаан бодож бэлтгэх хэрэгтэй.” Яагаад гэвэл “Агуу талархлын агуулга нь Есүс Христээр дамжуулан илэрхийлсэн Бурханы гайхамшигт түүх ба Ариун Зоогийн утга учрын талаар чуулган ямар ойлголттой байдгийг илтгэдэг учраас тэр билээ.” Төгсгөлд нь Бишоп болон пасторууд, итгэгчид нь Нэгдсэн Методист чуулганы албан ёсоор хүлээн зөвшөөрдөг магтуу болон мөргөл, мөн мөргөлтэй холбоотой гарын авлагд зааварчилсан үг ба зоогийн ширээний ёслолыг хэрэглэхээр уригддаг. Эдгээр бичвэрүүдийг нэр төртэйгөөр хэрэглэхдээ нөхцөл байдлын шаардлагад тохируулан уян хатан байлгаж, нэгдэл ба холбоо харилцааны ухамсрыг тусгахын тулд ёслолын дарааллыг өөрчлөх нь зөвшөөрөгддөг.

Асуулт: Ёслолыг удирдагч пастор нь хэзээ эхний талхыг хуваах вэ? – талхны тухай Есүсийн үгийг дамжуулахдаа хуваах уу, эсвэл дараа нь уу? Яагаад тэгж байгаа вэ?

Хариулт: The United Methodist Hymnal (11-р нүүр) ба The United Methodist Book of Worship (37,39-р нүүр)-д байгаа Ариун Зоогийн (institution narrative) хэсэгт удирдагчийн гаргах ёстой үйлдлийн талаар бичсэн хэсгээс (rubrics) харвал, талхыг Агуу Талархал ба Эзэний заасан гуйлтын дараа хуваахаар заасан байдаг. Энэхүү байр суурь нь Библид тулгуурласан бөгөөд хэрэгжихүйц байдаг. Библид тулгуурласан энэ байдал нь Сайнмэдээний номууд болон I Коринт дээр гарч буй Ариун Зоогийн харуулсан 4 төрлийн бүтэц (four – fold pattern)-ийг хүндэтгэн үзэхийн тулд юм: аваад (take), ерөөгөөд (bless),

хувааж (break), өгөх (give) – хэмээх дөрвөн бүтэцтэй. Ёслолд зоогийн ширээг бэлдэхдээ хэдийн ширээн дээр байгаа талх ба дарсыг хучсан хучлагыг аваад эсвэл талх ба дарсны зориулалтын төлөө тэдгээрийг ширээ рүү авч ирээд талх ба дарсыг “өргөдөг”. Дараа нь бид Агуу Талархалаар дамжуулан талх ба дарсыг бэлэг болгон өгсөн Бурханыг ерөөж талархдаг. Ийнхүү талархлаа өргөсний дараагаар цугласан байгаа итгэгчдэд өгөхийн тулд талхыг хуваана. Ерөөхийн тулд бид талхыг дээш өргөж, хүртээхийн тулд талхыг хуваадаг. Мөн түүнчлэн, Агуу Талархалын дараагаар талхыг хуваах бодит шалтгаан нь итгэгчдийн анхаарал удирдагчийн үйлдлээс илүүтэй Агуу

Талархалын залбиралд төвлөрдөг учраас тэр юм.



ЯМАР ҮЙЛ ЯВДАЛ БОЛДОГ ВЭ?

Ариун Зоогийн ёслолд талх ба дарсыг хуваалцангаа бид магадгүй хамгийн энгийн байдлаар Христээр дамжин илэрхийлэгдсэн Бурханыг таньж мэдэхийн хамт хөрштэйгөө нөхөрлөдөг. Талх ба дарсыг Эзэний зоогийн ширээнээ авчирч, талархлын залбирал өргөн, талхыг хувааж усан үзмийн дарсыг дүүргэн, хамт олноороо ариун хүнсийг хамтдаа хуваалцдаг. Эндээс бид “Түүхэн төдийгүй нийтлэг байдлаараа чуулган

нь Ариун Зоогийн ёслолд усан үзмийн дарсыг ашиглана” гэх үнэнд анхаарлаа хандуулдаг. Хэдийгээр усан үзмийн дарс ашиглахтай холбоотой хориглох заавар байхгүй ч, ерөнхийдөө Нэгдсэн Методист чуулган нь усан үзмийн шүүсийг ашигладаг. Энэ нь бид Есүс Христээр дамжуулан Бурхантай болон бусад итгэгч гишүүдтэйгээ харилцах харилцаанд ордог. Үүгээр дамжуулан бид Бурханы дуусахгүй хайр ба энэрэл, нигүүлслийг нь ухаардаг бөгөөд энэ бүх зүйл нь хэрхэн бий болдог талаар тайлбарлах нь амар биш ээ.

Баптисм, Библи уншлага, залбирал, мацаг барилт, Христитгэгчдийн мөргөл болон Ариун Зоогоор дамжуулан Бурханы хайрыг амсахдаа, Нэгдсэн Методист чуулганы итгэгчид нь ийм үйлдлүүдийг нийтлэг ивээлийн арга хэрэгсэл (*ordinary means of grace*) гэж нэрлэсээр ирсэн. Өөрөөр хэлбэл Бурханы бидэнтэй уулздаг арга хэрэгсэл нь хязгаарлагдмал биш ч, Бурханы хүүхдүүд нь Христитгэлийн түүхийн туршид дээр дурдсан арга хэрэгсэлүүдээр дамжуулан Бурханы ивээлийг амссаар ирсэн.

Иймэрхүү ивээлийн туршлага нь Бурхан энгийн хэлбэрээр бидэнд цутган өгсөн гэж итгэхэд хялбар байдаг. Гэвч Жон Весли ингэж ивээлийг мэдрэх нь Бурханы бэлэг бөгөөд энэхүү бэлгийг итгэлээр хүлээн авсан бидний хариу хандлагад ч бас түшиглэдэг гэдгийг давхар сануулсан байдаг. Дахин хэлбэл, Бурхан биднийг Өөрийнхөө баярын найрт урихад, тэрхүү найрт оролцох уу гэх шийдвэрийг бидэнд үлдээсэн гэсэн үг.

Весли Эзэний Зоогт оролцсоноор олж авах ашиг тусад давхар утга бий гэдэгт итгэсэн: Гэм нүглийн уучлалыг хүлээн аваад цаашлаад бид Христитгэгчээр амьдрах хүчийг олж авдаг. Уучлал ба хүчийг олж авдаг энэхүү хоёр утгыг агуулсан сэдэв нь өнөөдөр ч гэсэн Нэгдсэн Методист чуулганы итгэгчдийн Эзэний Зоогийг ойлгодог чухал агуулга юм. Гэхдээ бид Агуу Талархалын бүтцийг судлан харсан шиг, энэхүү хоёр сэдэв нь хувь хүний хийгээд нийгмийн түвшинд боломжтой болох болно. Ариун Хүнсээр дамжуулан бид сэтгэлийн хийгээд амьдралын ариун байдалд уригддаг.

Бид итгэлийг тээсэн хувь хүнийхээ хувьд уучлал ба хүчийг аваад зогсохгүй, мөн итгэлийн хамт олныхоо үүднээс ч гэсэн энэхүү бэлгийг хүлээн авдаг. Талархал өргөхдөө бид Бурханаас хүн төрөлхтөний түүхээр дамжуулан уучлал ба халамж гэх авралыг багтаасан үгээр итгэлийн хамт олон дээр ойртон ирснийг дурсан санадаг (жиш, Исаиа 40:1-11).

Бид Есүстэй хамт хооллохын тулд Галилын толгод болон дээврийн өрөөнд уригдсан хүмүүс нь Түүний дагалдагч хамт олон байсныг дурсан санадаг.

Мөн Есүс үхлээс амилсныхаа дараа цочролд орсон дагалдагчид (Иохан 20:19-23) болон Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалимд цугларсан хүмүүсийн дээр (Үйлс 2:1-42) Бурхан уучлал ба хүч чадлын Сүнсийг цутган өгсөнийг бид дурсан санадаг. Ариун Зоогоор дамжуулан бид хүчийг олдог нь итгэлийн хамт олон хүчийг олж буй хэрэг юм. Бэлэг болгон өгсөн талх ба дарс мөн хамт цугласан хүмүүсийн дээр Ариун Сүнс цутган буусан. Тиймээс бид дэлхийн төлөөх Христийн бие болж ертөнц дотор үйлчлэлийн ажлыг хийдэг.

ХРИСТИЙН БОДИТ ОРШИХУЙ

Дундад зуун болон шашны шинэчлэлийн цаг үед Ариун Зоогтой холбоотой асуултуудын нэг бол Христ хэрхэн талх ба дарсаар дамжуулан бидэнд Өөрийн оршихуйгаар ирдэг вэ гэсэн асуулт байлаа. Талх ба дарсанд Өөрийн оршихуйгаар ирдэг Христийн оршихуйн тухай асуултын хариултанд тухайн цаг үеийн онцлогыг агуулсан гүн ухааны чанартай бүтэц уусан орсон байдаг. Весли ахтайгаа энэхүү асуултын чухал чанарыг хүлээн зөвшөөрч байсан. Гэвч тэд гүн ухааны чанартай хариултаас илүүтэй бодит хариултыг чухалчилсан. Тэд Эзэний Зоогоос хүртэх Есүс Христийн доторх Бурханы ивээлийн бодит оршихуйд анхаарч байлаа. Чарльс Веслигийн бичсэн “Өө, Бурханы агуу хайр” (O the Depth of love Divine) магтаал нь дээрх асуултын хариултыг хураангуй хэлбэрээр өгсөн төдийгүй, өнөөгийн Нэгдсэн Методист Чуулганыханд тэрхүү хариултыг өгч байна.

Өө Бурханы агуу хайр
Хэмжээлшгүй их ивээл!
Талх ба дарсаар дамжуулан
Бурхан бидний дотор хэрхэн орж ирдгийг
Хэн хэлж чадах вэ!
Талхаар дамжуулан Түүний бие дамжуулагдаж
Усан үзмийн дарсаар дамжуулан Түүний цус дамжуулагдсан
Тэдгээрээр Түүний үнэнч ард түмний сэтгэл
Бурханы төгс амиар дүүргэгдэнэ!

Энэ дэлхийн хамгийн агуу ухаантай нэгнээр
Бид ийм ивээлийг хэрхэн авдгийг тайлбар хийлгэ
Талх ба усан үзмийн дарс нь өчүүхэн зүйлс мэт боловч
Тэдний өгч чадахгүй агуу хүчийг өглөө
Хэн ийм гайхамшгийг тайлбарлаж чадах вэ?
Ийм зүйлсээр дамжуулан гайхмаар үр дүн хэрхэн бий болов?
Талх ба дарсаар дамжуулан үр дүн бий болж байхад
Харин тэдгээр нь өөрчлөгдөөгүй хэвээрээ байх болно.

Ертөнцийн юмсад мансуурсан сүнсүүд
Бурханы өгсөн усан үзмийн дарсыг ууж
Үл устгах талхыг идээд
Хэрхэн тэнгэр өөд гарч чадав?
Бурханы мэргэн ухааныг асуу
Тэр арга замыг нь тогтоосон Христээс асуу
Бидний тахилын ширээний эргэн тойрон дахь тэнгэр элчүүд ч
Тэрхүү хариултыг нь хайгаад хайгаад олсонгүй.

Баттай бөгөөд бодитой зүйл нь ивээл юм
Гэвч тэр арга замыг нь мэдэж чадахгүй
Ивээл нь зөвхөн Бурханы арга замаар бидэнд ирж
Биднийг нэгхэн зүйлээр төгс болгосон.
Тэнгэрийн хүч чадлыг амталж үз
Эзэн, бид үүнээс өөр зүйлийг үл хүснэ
Ерөөл нь Таных бөгөөд
Гайхан биширч хүндлэн мөргөх нь биднийх.

Энэхүү магтуу нь дараах утга агуулгыг илэрхийлж байна. Зоогийн ширээнээ оршихуйгаараа ирдэг Христийг ухааран ойлгохыг оролдон хичээвч, Бурхан Өөрийнхөө ивээлийг хийгээд бидэнд хандсан хайраа хэрхэн дамжуулахыг нь сайн мэдэх аргагүй. Бид талх ба дарсыг хуваалцангаа зөвхөн дараах үнэнийг мэдэхэд л хангалттай: Бидэнд хандсан Бурханы хайр, бидний гэм нүглийн уучлал, хамт олноороо амьдрах бидний амьдралын төлөөх удирдлага, биднийг энэ дэлхийд үйлчлэхэд хэрэгтэй хүчийг өгснийг нь амсаж мэдрэх нь л хангалттай.



ХЭН АРИУН ЗООГИЙГ ХҮРТЭЖ БОЛОХ ВЭ?

Шинэ Гэрээнд гардаг анхны үеийн чуулганы баримтаас харвал Есүс Христийн сайнмэдээг хүлээн авсан хүн баптисм хүртсэнээр Христитгэлт хамт олны нэгээр амьдрахаар болдог. Баптисм бол чуулганы амьдралын гараа нь болсон.

Христийн үхэл ба амилалтыг бэлгэддэг баптисмыг хүртсэнээр юуны түрүүнд итгэгч хамт олны тоонд харьяалагдаж, үүний дараа гэд “элч нарын сургаал ба нөхөрлөл... талхаа хуваалцаж залбирах” зэргээр дамжуулан өсөж байлаа (Үйлс 2:42). Анхны чуулган нь баптисм болон Ариун Зоогийн харилцааг төрөлт ба төрөлтийн дараах өсөлтөд шаардлагатай хүнс гэж тайлбарласан. Ийнхүү Ариун хүнс нь бидний хүлээн авсан нүглийн уучлал ба Есүс Христийн дотор бидэнд үргэлжид өгч байдаг Бурханы ивээлийг батжуулж өгдөг.

Удаан хугацааны туршид чуулганы түүх болон амьдралаар дамжуулан, баптисм нь Эзэний Зоогт оролцох ёслол болон үйлдэгддэг байв. Эзэний зоогийн ширээн дэх нөхөрлөлд баптисм хүртсэн хүн л оролцох эрхтэй ба чуулган нь Ариун Зоогийн ариун чанарыг хадгалах гэж тэмүүлсэн. Ингэж хязгаарлах болсон нь зарим нэг хүнд Ариун Зоогийн нөхөрлөлд оролцохын тулд христитгэгчийнхээ хувьд үндсэн сургалт шаардлагатай гэсэн чуулганы ойлголтоос болжээ. Гэвч чуулган ийм ойлголтыг хэрэглээ болгохдоо уян хатан байж чадаагүй. Баптисм хүртсэн

хүүхдүүд эсвэл баптисм хүртсэн боловч, оюун санаандаа бүрэн төгс байж чадаагүй хүмүүсийг Ариун Зоогт оролцохыг нь байнга хориглож байлаа. Гэхдээ хэрвээ баптисм нь Эзэний Зоогт оролцох эрх нь болдог юм бол, баптисм хүртсэн хүмүүс нас, ур чадвараас үл хамааран бүгд Ариун Зоогт оролцох боломжтой байх хэрэгтэй.

Тэгвэл нээлттэй Ариун Зоог гэж юу вэ? Англи дахь анхны үеийн методист хөдөлгөөний үед Ариун Зоогтой холбоотой ойлголт хийгээд хэрэгжүүлэлтийн хувьд хэд хэдэн асуудал гарч ирсэн. Хөдөлгөөнд оролцогсдын ихэнх нь Английн төрийн чуулганаас бага насны хүүхэд байхдаа баптисм хүртсэн хүмүүс байлаа. Тиймээс Ариун Зоогийг хүртэх нь тэдний эрх байсан хэдий ч маш цөөн хүмүүс л Эзэний Зоогт оролцдог байлаа. Үүний талаарх хариу үйлдэл болгож Весли нь бүх методистууд болж л өгвөл байнга Ариун Зоогт оролцож байхаар урамшуулж байсан юм.

Өөр нэг талаараа Весли Ариун Зоог хүртэхээр цугласан хүмүүс нь баптисм хүртсэн байсан ч энэ нь тэдний ариун байдлыг батлан дааж чадахгүй гэдгийг анзаарчээ. Үүний хариу үйлдэл болгож, Весли христитгэгчид нь Христэд итгэх итгэлээрээ сэргэг байж Ариун Сүнсний хүч чадлаар шинээр төрөхийг хүсэмжилж байв. Эзэний Зоогоор дамжуулан хүмүүсийн итгэл шинэчлэгдэхийг ажигласан Весли нь хүмүүс шинээр гэмшин эргэхэд чиглүүлэх ёслол хэмээн Эзэний Зоогийг ухаарсан байна. Мөн Весли нь Христийн дотор шинэ амьдралаар амьдрахыг хүссэн бүх хүнийг Эзэний Зоогийн ширээнд урьсан. Весли нь шинээр гэх итгэлийн хатуу шийдвэрээр Эзэний ширээ рүү ирж буй хүмүүс нь мэдээж баптисм хүртсэн байгаа гэж үзжээ.

Нэгдсэн Методист чуулган нь Ариун Зоогийг нүглийн уучлал болон нигүүлсэлд баг итгэж, шинээр амьдрахаар шийдсэн эргэлтийн ёслол (a converting ordinance) гэж үзсэн учраас өнөөдөр ч гэсэн бүх хүмүүст нээлттэйгээр Ариун Зоогийг барьдаг. Христитгэгчийн амьдралаар амьдрахыг хүссэн бүх хүн нас, ур чадвар, урсгал чиглэлээс үл хамааран Ариун Хүнснийг хуваалцахын төлөөх Эзэний ширээнээ уригддаг (хаалттай Ариун Зоогийг барьдаг чуулганууд нь баптисм хүртээд, онцлог бүхий урсгал чиглэлд харьяалагдсан хүмүүсийг л Ариун Зоогт урьдаг. Ийм чуулгануудад зочлон мөргөл өргөж буй Нэгдсэн Методист чуулганы итгэгчид нь ийм хязгаарлалтыг даган хүлээн авах учиртай).

Өнөөдөр Нэгдсэн Методист чуулганы олон бие даасан чуулгануудад Эзэний ширээнээ хүмүүсийг урихдаа зөвхөн зөвт хүмүүсийг төдийгүй гэм нүгэлтнүүдийг ч хамтад нь урьсан Есүсийг санах хэрэгтэй.

Цаашлаад бидний уригдсан зоогийн ширээ нь ямар нэг онцлог бүхий гишүүд юмуу урсгал чиглэлд харьяалагддаг биш харин Есүс Христэд л харьяалагддаг гэдгийг санах хэрэгтэй.

Христтэй хамтдаа хооллохоор биднийг урьсан Нэгэн бол Христ Өөрөө билээ. Гиймээс Эзэний ширээнээ ирэх гэсэн бүх хүнийг урих нь чуулганы тогтсон дүрэм журамтай зөрчилдөх тохиолдол бий. Бид Эзэний Зоогийг хуваалцахаар ирж буй ямар ч хүнээс татгалзахгүй. Татгалзах үйлдэл нь Эзэний нигүүлсэлд харшилж буй хэрэг болно. Харин бусад тал дээр буюу баптисмтай холбоотой Нэгдсэн Методист чуулганы албан ёсны тунхаг болох “Ус ба Ариун Сүнсээр” (By Water and the Spirit)- хэсэгт дараах үгс байдаг: Бид Ариун Зоогт оролцоходоо баптисм хүртэхэд бидэнд цутган өгсөн нигүүлслийг санадаг. Мөн авралын амлалтыг хадгалж, биелэл болгоход шаардлагатай сүнслэг хүнсийг хамтдаа хүртэнэ... Баптисм хүртээгүй хирнээ Ариун Зоогийг хүртэж буй хүнд зөвлөгөө өгөх хэрэгтэй бөгөөд болж өгвөл ойрын хугацаанд баптисм хүртэхээр халамжлах хэрэгтэй.

Ариун Зоогоос ирдэг ивээлт бэлэг нь Ариун Зоогийг хүртэж буй хүнийг хувь хүний зориулалт уруу хөтлөх итгэл болон хайраас гарах үйлдэлд хүргэдэг.

ХЭН АРИУН ЗООГИЙГ ХҮРТЭЖ БОЛОХ ТУХАЙ АСУУЛТУУД

Асуулт: Хэдэн наснаасаа эхлэн Ариун Зоогт оролцож болох вэ? Эхлээд Баптисм хүртэх ёстой юу? Заавал чуулганы итгэгч байх хэрэгтэй юу?

Хариулт: Нэгдсэн Методист чуулган нь Ариун Зоогийн ёслолд оролцоход нас болоод эрхийн хувьд ямарваа нэгэн шалгуур тавьдаггүй. Энэхүү зарчмаар Баптисмын утга учир болон хэрэгжүүлэлтийн талаарх бидний үзэл бодлыг тайлбарладаг “The United Methodist Book of Worship болон By Water and the Spirit” -ээс харж болно. Дээрх номд “Христитгэгчийн

амьдралаар амьдрахыг хүссэн хүн бүр хүүхдүүдийнхээ хамт талх ба дарсыг хүртэхээр уригддаг” гэдгийг онцолдог бол “Water and the Spirit” – д “Бидний оролцдог зоогийн ширээ нь Эзэнд харьяалагддаг учраас Христийн хайранд хариулж буй хүмүүс нь нас, эсвэл тухайн чуулганы итгэгч байх эсэхээс үл хамааран хүн бүр оролцож болно.” хэмээн бас бичсэн байдаг. Ингэснээрээ бид наснаас үл шалтгаалан бүгд оролцож болох Ариун ёслолын тухайд хүмүүсийн насанд нь тохирсон дасгалжуулалт болон боловсролыг явуулах үүргийг хүлээж байна.

Ариун Зоогт оролцоход шаардлагатай болзолын тухай асуултын талаар дээр дурьдсанчлан, ТНМ – д сайнмэдээ төвтэй нээлттэйгээр уригдах хийгээд Христитгэлийн дасгалжуулалт хоёрын дунд багахан түгшүүр байдаг: учир нь “Баптисм хүртээгүй ч, Ариун Зоогт оролцох урилгад итгэлээрээ хариулж буй хүмүүс нь Эзэний зоогийн ширээнд баяртайгаар уригддаг.” Гэвч нөгөө талаар “Ихэнхдээ баптисм нь Ариун Зоогт оролцохоос өмнө үйлдэж хүлээн авдаг зүйл. Ариун Зоог бол Есүс Христийн дотор Бурхантай гэрээ байгуулсан хамт олны хамтдаа хуваалцдаг зоог юм.”

ХЭН АРИУН ЗООГИЙГ ХҮРТЭХ ЭРХТЭЙ ВЭ?

Ариун Зоогийн ёслол нь бүх хүмүүст нээлттэй эсвэл хаалттай байдаг эсэхэд бус харин Ариун зоогийн ёслолд харшлах зүйлгүйгээр үүнийг хуваалцах тал дээр чуулган эртнээс анхаарсаар ирсэн. Ингэж анхаарах болсон нь Ариун бэлэг болох талх ба дарсыг зөвхөн ариун хүмүүс л хуваалцаж болно гэсэн чуулганы мөрөөдлөөс бий болсон. Зоогт оролцох эрхтэй холбоотой бидний энэхүү сонирхол нь методист чуулганы түүхийн явцад мөргөлийн нэг хэсэг байсан “Даруугаар ойртон очих залбирал” – д үргэлж тусгагддаг байсан. Методист

чуулганы олон итгэгчид амьдралынхаа туршид дараах залбирлыг сонсож мөн үйлдсэнээр өсөж ирсэн. “Бид бол Таны зоогийн ширээн дор унасан үйрмэгийг ч цуглуулах эрхгүй хүмүүс.” Гэсэн ч энэ өгүүлбэр нь Бурхан бол өршөөнгүй Нэгэн гэдгийг бидэнд сануулдаг дараах өгүүлбэртэй байнга холбогддог. “Гэсэн ч Та бол энэрэнгүй нигүүлсэнгүй Эзэн мөн.”



Мөн оролцох эрхтэй холбоотой ойлголт нь 1Коринт 11:27-29 эшлэл дэх Паулын сануулгыг буруу тайлбарласнаас үүдэлтэй:

“Тиймд хэн нэгэн хүн зохисгүйгээр Эзэний талхыг идэж, аяганаас уух аваас Эзэний бие ба цусны буруутан болно. Харин хүн өөрийгөө шалгаж байгаад талхыг идэж, аяганаас ууг Учир нь идэж буй хүн хэрэв биеийг зөв шүүлгүй идэж,уувал өөртөө шийтгэл авчирна.”

Паул уг эшлэлийг Коринт чуулганд гараад байсан хоол хүнстэй холбоотой онцгой асуудлын хүрээнд л дурдсан болохоос биш, хувь хүний оролцох эрхийн тухай өгүүлээгүй. Паулын сануулга нь бид зөвхөн хувь хүнийхээ хувьд төдийгүй итгэлийн хамт олон болохын хувьд ариун амьдралаар амьдруулахын тулд бидний анхаарлыг татдаг. Паул чуулганы итгэгч болох бидэнд төдийгүй Христийн бие болох чуулганд ч энэ ертөнцөд хэрхэн амьдрах учиртайг анхааруулан сануулдаг.

Чарльс Весли нь “Бүгд сайн мэдээний найранд ирэгтүн” гэх магтан дуугаараа бидний хэр зохистой байдлаар идэж ууж буй тухай асуудлыг гаргаж тавьсан.

Ирэгтүн, нүгэлтнүүд ээ, сайн мэдээний найранд ир
Бүх сүнснүүд Есүсийн зочин боллоо
Та нар хойно хоцрох хэрэггүй ээ
Бурхан бүх хүмүүсийг бүгдийг нь дуудсан.

Шалтаг тоочихоо больё
Та нар Түүний нигүүлслээс татгалзах хэрэггүй

Та нар ертөнцийн зовнил хийгээд зугаа цэнгэлээ бүгдийг нь хаяад
Есүсийн өгч байгааг аваарай.

Бид хэн байхаас үл хамааран, Бурхан хүн нэг бүрийг сайнмэдээнийхээ найранд урьсан. Есүс биднийг тэрхүү найранд аваачихын тулд хүлээн зогсож байгаа. Урилга бол бидний хүлээн авах ёстой зүйл.

ХЭДЭН УДАА?

Веслигийн хөдөлгөөн (Wesleyan movement) нь сайнмэдээ болон Ариун Зоогийн хувьд сэргэлт авчирсан гэж ойлгогдож байлаа. Гэвч Америкт чуулган анх тарьсан газар нутаг дахь методист хөдөлгөөний өсөлт нь анхан үеийн методист чуулган хийгээд Английн төрийн чуулган хоорондын харилцаанаас болж сэргэлт авчирсан гэж хэлэхэд бэрхшээлтэй байдаг. Америкийн хойд хэсгийн методист чуулганы өвөрмөц түүх нь Ариун Зоогийн ёслолын давтамж нь тогтсон биш янз бүр байдгийг хэд хэдэн хэлбэрээр тайлбарлаж өгдөг. Протестант урсгалын шинэчлэгчид (Мартин Лютер, Жон Калвин гэх мэт) төдийгүй анхны чуулган ч гэсэн Эзний өдөрт Ариун Зоогийг барьдаг байсан. Тэгсэн мөртлөө чуулганы түүх нь тоо хэмжээ болон хэрэгжүүлэлтийн хувьд удаан хугацааны туршид зөрчилдсөөр ирснийг харуулдаг.

Веслигийн үед хөдөө нутгийн чуулганууд улиралд нэг удаа Ариун Зоогийг барьдаг байсан. Хотын чуулганууд нь илүү олон удаа барьдаг байжээ. Английн төрийн чуулганы тогтоолоос харвал христитгэгч нь хамгийн багадаа жилд нэг удаа буюу тэр нь амилалтын баярын үеэр Ариун Зоогийг барьдаг байхаар тогтсон байдаг. Ариун Зоогийг байнга барихаас татгалзах шалтгааны нэг нь Ариун Зоогийг хүртэх эрхийн талаарх зовнил (өмнөх хэсгээс харсанчлан) болон энэ эрхийг авахын тулд хувь хүн өөрийгөө бэлдэх шаардлагатай байдаг учраас тэр юм.

Ийм нөхцөл байдал нь Веслийг “тасралтгүйгээр өргөх Ариун Зоогийн үүрэг” гэх номлолоо хийхэд хүргэсэн. Весли нь Ариун Зоогийг болж өгвөл байнга барих нь христитгэгчийн үүрэг гэж онцолсон. Түүний онцолж буй нь Бурхан биднийг Өөрийнхөө тушаалыг хааяа нэг дагах биш, харин байнга дагадаг байхаар дуудсан гэдгийг тодотгож өгдөг. Ариун Зоогийг хүртэх эрх мөн Ариун Зоогийг барихаас өмнө тохирох

бэлтгэлийг хангах гэсэн чин хүсэлтэй нь холбоотой асуултад Весли хариулахдаа, методист чуулганы итгэгч нар Ариун Зоогийг барьж болохуйцаар цаг үргэлж бэлэн байдалд байх хэрэгтэй гэж хэлсэн. Дараа нь тэрээр бид хүртэх эрхгүй ч Бурхан бидэнд нигүүлслээ буулган өгдөг Нэгэн гэдгийг сануулж өгдөг.

Америк дахь анхан үеийн методист чуулганд Ариун Зоогийг олон удаа барьж чаддаггүй байсан шалтгаан нь Ариун Зоогийг удирдах тослогдсон пасторууд цөөн байснаас болж байлаа. Энэхүү байдал зовнисон Весли өөрийн методист чуулганы номлогчдод тосолгоог өгсөн. Весли нь тосолгоо авсан пасторууддаа долоо хоног бүр Ариун Зоогийг барьж байхыг зөвлөсөн байдаг.

19-р зуун болон 20-р зуунд Америкийн методист чуулганд Ариун Зоогийг байнга барьж чадаагүй олон шалтгаан байсан. Хөдөөгийн чуулганд тосолгоо авсан пастор хааяа л нэг ирдэг байсан учраас долоо хоног бүр Ариун Зоогийг барих нь бэрхшээлтэй байв. Зарим хүмүүс Ариун Зоогийг байнга баривал Ариун Зоогт дэндүү дасал болж энэ нь хувь хүний зохистой бэлтгэлд хойрго хандахад хүргэнэ хэмээн үздэг байлаа. 19-р зууны эхэн үед сайнмэдээ тараах хөтөлбөрийн үеэр (camp meetings) Ариун Зоогийг барьдаг байсан ба номлолоос ивээл авсан хүмүүс баптисм хүртээд Ариун Зоогт оролцохоор шийдвэр гаргадаг байжээ. Ийм зүйл гарч байсан ч Америкийн хязгаар нутгаас жинхэнэ итгэгчийг олохын төлөөх чуулганы анхаарал нь эцэстээ Ариун Зоогоор дамжуулан олох итгэлийн баг байдал ба өсөлтөнд тавих анхаарлыг багасгах болсон. Өнөөдөр ч гэсэн дээр дурдсан эрхтэй холбоотой асуудал, дэндүү дасал болсон асуудал, баптисм хүртэхээр шийдвэр гаргаж байгаа хүнийг эхлээд олох асуудал бүр цаашлаад Ариун Зоогийн улмаас мөргөлийн цаг дэндүү уртсах явдлыг хүсэхгүй байгаа өнөөгийн бодит байдалд анхаарлаа хандуулсаар байна.

Ариун Зоогийг хүртэх тооны давтамжийн асуудал нь өнөөдөр ч оршсоор байгаа боловч, олон зууныг дамнасан чуулганы тухай яриа болон мэдлэг, онол мөн мөргөлийн шинэчлэлт нь Нэгдсэн Методист чуулган Ариун Зоогийн ёслолыг долоо хоног бүр барьж байхаар хөтөлдөг. Өнгөрсөн хугацаанд илүү их, байнга Ариун Зоог барих тал руугаа явсан байна. Нэгдсэн Методист чуулгануудаас зарим нэг чуулган нь долоо хоног бүр Ариун Зоогийг барьдаг – зарим тохиолдолд онцгой мөргөл дээр барьж, мөн зарим тохиолдолд Эзэний өдрийн мөргөл дээр барина. Америк дахь Нэгдсэн Методист чуулгануудаас ихэнх нь сард нэг удаа Ариун Зоогийг барьдаг ба голдуу эхний долоо хоногийн Эзэний өдөр барьдаг. Мөн зарим нэг чуулган нь Христийн

мэндэлсэн баярын өдөр, Их Эзэн дагалдагч нартаа харагдсан өдрүүдэд, Ариун дөрөв дэх өдөр³, Амилсны өдөр, бас Дээгүүр Өнгөрөх баярын өдөр зэрэг чуулганы хуанлийг даган онцгой өдөрт Ариун Зоогийг барьдаг. Ариун Зоог нь өдөр тутмын ёс шиг үйлддэггүй газарт ч, христитгэгчид долоо хоног бүрт Ариун Зоогт оролцох нь хэвийн зүйл гэж үзэх хандлага байдаг.

Эцэст нь, урилга ба тэрхүү урилгад хариулах халуун сэтгэл, хүсэл нь биднийг Христ болон христитгэлт хамт олонтой Ариун Зоогийг хуваалцахад дагуулдаг. Ариун Зоогоор дамжуулан хүртэх Бурханы нигүүлсэл нь биднийг болж өгвөл байнга Ариун Зоогийг хүртэхийг ятгадаг.

ДАВТАМЖ БА ЦАГ ҮЕИЙН ТАЛААРХ АСУУДАЛ

Асуулт: Маш олон христэч хүмүүс Ариун Зоогт тэглээ дуртай байдаггүй учраас Ариун Зоогтой өдөр чуулгандаа ирдэггүй. Тэгсэн ч гэсэн Ариун Зоогийг үргэлжлүүлэн сар бүрийн эхний Эзэний өдөрт барьсаар байх уу? Эсвэл онцгой өдрүүдэд л барих уу?

Хариулт: Уг асуултад хоёр шатны хариулт хэрэгтэй. Юуны өмнө итгэгчид Эзэний өдөр бүр Ариун Зоогт оролцохгүй байгаа шалтгаан нь юу болохыг олж мэдэх хэрэгтэй. Итгэгчид Ариун Зоогийн талаар буруугаар эсвэл дутуу дулимаг ойлгосноос шалтгаалж байгаа бол итгэгч нартаа Ариун Зоогийн талаарх зөв ойлголтыг өгөх сургалтыг явуулснаар асуудлыг шийдвэрлэж болно. ТНМ -д Ариун ёслол нь амьдрал дотор элбэг дүүрнээр үйлдэгдэхэд ашиг тустай бөгөөд, Ариун Зоогоор дамжуулан хүмүүс “Христийн бие болох итгэгчидтэйгээ илүү амьд харилцаа”-тай болох ба энэ боломжийг Ариун Зоог өгдөг гэж хэлдэг.

³ Есүс загалмай дээр цовдлогдсон өдөр

Хэрвээ тэд чуулганд барьдаг Ариун Зоогийн явцыг үргэлжлэх хугацааны хувьд эсвэл Ариун Зоогийн ёслолыг хайнга барих гэх асуудлууд байна гэж үзвэл Ариун Зоогийн ёслолын хэлбэр юмуу агуулга, хэрэгжүүлэлт нь байх ёстой бүхий л шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг нягтлан үзэж болох юм. ТНМ хамт давхар харах ном бол “Гайхамшиг дотор амьдрах” (Living into the Mystery) бөгөөд дараах үндсэн зарчмыг зааж өгдөг: “Бодит бай. Бүү яар. Үйлдэлдээ тааруул. Мөргөлөө өргө. Өөрийнхөө өгч чадах хамгийн сайныг өг. Өөрийнхөө удирдах чадвараар дамжуулан мөн мөргөлд оролцсоноороо та ч мөн адил Ариун Сүнсний эрх мэдэл дотор Христийн үнэт цусаар авралыг авсан Христийн бие мөн гэдгээ харуул.”

Хоёрдугаарт, Ариун Зоогийн давтамж бага байхтай холбоотой хариулт юм. ТНМ – с харвал “Эзэний дагалдагчийн амьдралыг хүсэмжлэгч хүмүүс нь Бурханы үг болон Ариун Зоогоор дамжуулан өгөгддөг сүнслэг хангамжийг байнга эрэлхийлнэ.” Тиймээс итгэгчид нь үнэхээр “Эзэний өдрийн мөргөл бүр дээр” нэмээд “чуулганы онцгой өдөр бүр барих Ариун Зоогт оролцохоор” ятгагдах хэрэгтэй. Дахин хэлэхэд, сар бүрийн эхний Эзэний өдөрт л Ариун Зоогийг барих нь хамгийн бага хэмжээгээр хэрэгжүүлж буй тохиолдол болох бөгөөд, бид Ариун Зоогийг байнга барьдаг байх хэрэгтэй.

АРИУН ЗООГИЙГ БАРИХ ХЭЛБЭРҮҮД

Бидний хувьд Ариун Зоогийг хэр их барьж байгаа маань Ариун хүнсний хэрхэн ойлгож буйг минь хэлж өгдөг. Цаашлаад талх ба усан үзмийн дарсыг хүртэх арга хэлбэр маань ч гэсэн Ариун хүнсний талаарх бидний ойлголтыг илэрхийлдэг. Мөн бид талх ба дарсыг хэрхэн хүлээн авч байгаа нь Нэгдсэн Методист чуулганы доторх олон янзын түүхийг тусган харуулдаг. Нэгдсэн Методист чуулган нь Евангелийн чуулган (Evangelical), Нэгдсэн Чуулган (United Brethren),

мөн Методист Чуулган (Methodist)- ны уламжлалуудаас бүрэлдэн гарч ирсэн. Тиймээс Нэгдсэн Методист чуулганд цор ганц гэх зөв арга байх боломжгүй. Ариун Зоогийг хүртэхэд зохимжтой арга хэлбэрүүд олон байдаг ч арга тус бүр нь Ариун Зоогийн ёслол нь ямар байдаг талаар өөр өөрийн ойлголтуудыг чухалчилдаг. Нэгдсэн Методист чуулганаас зарим нэг нь жижиг тавган дээр талх болон дарсыг өгч итгэгч нар нь суудалдаа суусан чигээрээ зоогоос хүртдэг. Мөн зарим чуулганд итгэгчид нь ариунаар тусгаарлагдсан (chancel) хэсэг уруу гарч очоод талх ба дарсыг гардан авахдаа өвдөг сөхрөн хүртдэг. Зарим чуулганд талх ба дарсыг гардан авахын тулд хүмүүс индэрийн өмнө ч юмуу зассан Ариун Зоогийн ширээнээ дараалан зогсдог.

Дээрх янз бүрийн хэлбэрүүд болох – суугаад, өвдөг сөхрөөд эсвэл зогсоод – энэ бүгдээрээ Ариун Зоогийн талаарх бидний ойлголтыг тодорхой хэмжээгээр илэрхийлж байдаг.

Зарим хүмүүсийн хувьд талх ба дарсыг авч ирэхэд суудалдаа суусан чигтээ хүлээн авах нь, бид уригдаад суудалдаа сууснаар найранд оролцохоор дуудагдсан гэдгийг сануулж өгдөг. Мөн Бурхан эхэлж бидэн дээр ирээд Есүс Христийн дотор хайр ба нигүүлслээ цутгаж өгснийг сануулдаг. Нэг болгосон Эзэний зоогийн ширээнээ тойрон суугаад, элбэг дүүрэн зассан ширээн дээр алт болон мөнгөн тавагтай зүйлсийг хүлээн авдаг.

Бид Ариун Зоогийн ширээнд (altar rail) ирэн өвдөг сөгдөж буй нь Эзэний зоогийн ширээнээ ирэгтүн гэсэн урилгад хариулж буй хэрэг юм. Бурхан хэдийнээ бидэн дээр ирээд, тэрхүү урилгад нь хариулах бидний хариу үйлдлийг хүлээн авдаг гэдгийг бид ухаарч, түүнд хариулан урагш гарч байгаа юм. Гэхдээ индрийн өмнө сөгдсөнөөр биднийг урьсан Нэгэн бол тэнгэр ба газар бүх ертөнцийг захирагч Эзэн гэдгийг бид хүлээн зөвшөөрч буй хэрэг. Ариун Эзэний зоогийн ширээнээ ойртуулахгүйгээр хашилтаар хааж өгсөн нь Бурханы өмнөх бидний байр суурийг хэлж өгдөг. Ариун Бурханы сэнтий рүү ойртох эрхгүй нэгэн учраас бид өвдөг сөгдөн, толгойгоо гудайлган, даруугаар Бурханы энэрэл нигүүлслийг хүсэмжилдэг.

Бид ариун идээг багтаасан индэр рүү ойртон очихдоо суудлаасаа босон бэлдсэн зүгт очоод талх ба дарсыг гардан авч байгаа нь бид Бурханы урилгад бие махбодиороо хариулж байгаа явдал болно. Бид “Ирэгтүн, хамтдаа идэцгээе” гэх урилгыг сонсоод явж очдог. Зогссон тэр чигтээ ёслолд оролцож байгаа нь баяр хөөр болон талархалтайгаар зоогийн ширээнд ойртон очиж буйг илтгэдэг. Бид нүглээ өчөөд, тэрхүү



нүглийн уучлалын баталгаа бүхий үгийг сонсох юм бол, энэ нь зоогийн ширээнээ цуглан Бурханд талархал өргөж буй нь зөв бөгөөд сайн, сайшаалтай хэрэг билээ.

Зарим чуулганд Ариун Зоогийн ёслолд нэг ширхэг “хундага”-ыг нийтээрээ хэрэглэж (илүү том чуулганд том “хундага”-ыг хэд хэдээр нь ашиглана) талх ч гэсэн нэг талхыг хувааж хэрэглэдэг. Зарим чуулганд бол хүн тус бүрд аяга болон зургаан өнцөг бүхий хэлбэртэй талхыг “сагс”нд хийгээд хэрэглэдэг.

Тус тус аягыг ашигласан нь 20-р зууны эхээр дэлгэрсэн бөгөөд, үүний нэг шалтгаан нь халдварт өвчний талаарх мэдлэг нэмэгдэж, ханиад мэтийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд байв. Өнөө цагт ч гэсэн тус тусын зүйлийг ашиглаж байгаа нь халдвар үүсгэж болох нянгаас болсон. Гэхдээ Ариун Зоогийн ерөнхий онцлогийг авч үзэхэд, хувийн жижиг аягыг ашиглах нь итгэгч хоорондын гэхээсээ илүү хувь хүний Бурхантай нөхөрлөх сэтгэлийг чухалчлах хандлагатай байдаг. Зарим чуулганд энэ талыг нягталж үзээд, итгэгчдэд бүгдэд нь талх ба дарсыг тараан өгтөл өөрийнхөө талх ба дарсыг барьсан хэвээр хүлээхийг хүссэнээр итгэгчид бүгдээрээ хамтдаа идэж уудаг.

Чуулганы түүхээс харвал дарсыг хамтдаа хуваалцаж (хэрэглэж) нэг бүтэн талхыг хуваан хэрэглэх нь илүү түгээмэл байжээ. Бидний сонирхолыг татдаг зүйл нь Библид Маркын дээврийн өрөөнд Есүс

дарсыг дагалдагч нартайгаа нэг л хундаганаас хэрэглэсэн ба нэг л талхыг хуваасан. Энэ нь мөн IКоринт 10:16-17 (NRSV)-д Паулын хэлсэн үгийг санагдуулдаг.

“Бидний ерөөдөг ерөөлийн аяга нь Христийн цусан дахь оролцоо биш үү? Бидний хуваадаг талх нь Христийн бие дэх оролцоо биш үү? Талх нэг тул бид ч олуулаа нэг бие...”

Нэгдсэн Методист чуулганд Ариун Зоогийг хэрхэн барихыг шийдэх шалтгаан нь итгэгчид Бурхан болон хөрштэйгөө харилцах харилцаанд илүү дотносоход нь туслахын төлөөх хоньчлолоос болсон гэхээсээ илүү Ариун Зоогийг барихад хэр их хугацааг зарцуулж байгааг бодож үзсэнээс болсон. Суусан ч бай, өвдөг сөгдсөн ч бай зогссон ч бай, мөн нэг л аяганаас нийгээрээ хүртэх, эсвэл тус тусын аягыг ашиглах аль нь ч бай, Эзэний Зоогийг хамтдаа хуваалцсанаар бид Бурхантай болон итгэгч нартайгаа ариун нөхөрлөлийг бий болгохын төлөө байдаг.

БУСАД АСУУЛТУУД

Ариун Зоогтой холбоотой энэхүү янз бүрийн гүйцэтгэл болон ойлголтоос болж, Ариун Зоогийн ёслолын явцад эдүгээ хэрэглэгдэж ирсэн бидний теологийг бүрэн дагахгүй байх явдал гардаг эсэх талаар асуух нь мэдээж хэрэг. Энэхүү гарын авлагад хэлэлцэж буй хэд хэдэн асуулт бий. Эхлээд бодит байдлын үүднээс ч бай бэлгэдлийн чанартай ч бай, бидний хэрэглэдэг талх бол жинхэнэ талх байх нь чухал. Энэ талхаар бидний хүлээн авч буй зүйл нь үнэхээр амийн талх гэдгийг сануулж, мөн үүн дотроо биднийг оролцохыг урьдаг.

Хоёрдугаарт, Паулын сургамжилсны дагуу бидний дунд оршдог Бурханы биеийг ухамсарлах учиртай. Тэгснээрээ Бурхантай болон хөрштэйгөө хамтдаа бий болгож буй ариун зан чанар нь тодорхойгүй Ариун Зоог нь – ганцаараа аваачаад иддэгсэн үү, талх ба дарсыг урьдаас тусгаарлаад ширээнд тавьж хүмүүс хүссэн цагтаа ирээд Ариун Зоогийг барьж болохуйцаар хийх нь– Нэгдсэн Методист чуулганы ойлгодог Ариун Зоогоос ялгаатай байдаг.

Эцэст нь Ариун Зоогийн ёслолоос баптисм хүртсэн хүнийг хасах нь, тэр дундаа баптисм хүртсэн хүүхэд эсвэл ойлгох чадвар дутагдалтай хүмүүсийг хасах нь Эзэний биеийг ялгаж чадахгүйтэй адил юм.

АРИУН ЁСЛОЛ ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД

Асуулт: Христмас баярын өмнөх шөнө “Come and Go” (Хүн бүр хүссэн цагтаа ирээд хүртэх) Ариун Зоогд ёслолын ямар заалттай номыг ашигладаг вэ? Пасторуудаас хэн нэгэн нь тэнд байх хэрэгтэй юу, эсвэл хүмүүс өөрөө өөрсдөө талх ба дарсыг хүртэж болохоор тусгаарлагдсан ширээнд тавих уу?

Хариулт: Өмнө дурдсанчлан ТНМ нь “Ёслолын цаг болохоос өмнө талх ба дарсыг урьдаас ариусган тусгаарладаг нь... зохисгүй бөгөөд, Бурханы ивээл нь ариун ёслол дотор хэрхэн оршихтой холбоотой бидний уламжлалт зарчим ба ойлголтод эсрэг байна (Article XVIII, The Article of Religion, зарчим ба дүрэм номын 64-р нүүр).”

Энэ нь талх ба дарс нь “итгэгчдийг цугласан байхад ариунаар тусгаарлагдан хүртээгдэх ёстой” гэсэн зарчимтай зөрчилддөг. Өөрөөр хэлбэл бидний барьж буй Ариун Зоогийн ёслол нь энгийн утгаараа хувь хүн ба Бурханы хоорондох солилцоо төдий зүйл огт биш. Үүгээр дамжуулан бид бие биетэйгээ дотносон нөхөрлөдөг. Ариун зоог нь орон нутгийн чуулганд ч дэлхийн чуулганд ч итгэлийн хамт олны хамтдаа мэдэрч хуваалцах зүйл юм. Мэдээж Ариун Зоог нь оролцож буй хувь хүмүүст ч гүн утгатай боловч, энэ нь хувийн гэх ойлголтоос хавьгүй гүн утгатай. Эзэний зоогийн ширээнд мэдэрч болох хуваалцал ба нэгдэл нь чуулганы мөн чанар болон Бурханы хүсч буй ертөнцийн загварыг харуулдаг.

Итгэгчид хамтдаа цуглан үйлдэх тухай зарчим нь ТНМ – д маш тодорхойгоор илэрхийлэгдсэн байдаг. “Хүмүүс өөрөө өөрсдөө талх ба дарсыг хүртдэг ‘өөртөө үйлчлэх’ Ариун Зоог, мөн талх ба дарсыг тодорхой хугацааны туршид хүмүүс хүссэн үедээ ирээд зоогоос хүртэж байхаар ‘саадгүйгээр’ (drop-in) тавьсан Ариун Зоог нь уламжлалт Зоогийн өгөх онцлогтой эсрэгцдэг. Ариун Зоогийг итгэлийн хүмүүс хамтдаа хүртдэг.”

Асуулт: Бид онлайнгаар оролцохыг хүссэн хүмүүсийн төлөө мөргөлийг шууд дамжуулдаг. Тэдэнтэй хамтдаа Ариун Зоогийг барих тохиромжтой арга зам бий юу?

Хариулт: Энэ асуултын хариулт нь хэдийгээр “саадгүйгээр” Ариун Зоогийг хүртэхээс илүү төвөгтэй ч ижил зарчимд тулгуурлана.

Үндсэндээ шаардагдаж байгаа зүйл бол Ариун Зоогийн ёслолд ашиглагддаг талх ба дарс нь “итгэгчдийг хамтдаа цугласан байхад ариунаар тусгаарлагдаж хуваарилагдах ёстой” гэсэн зарчим юм. Ийм зарчим нь энэхүү номын өмнөх хэсгүүдэд гарч байгаа ба үүн дээр тулгуурладаг.

Ариун зоог нь тус чуулганы мөн орон нутгийн чуулганд ч дэлхийн чуулганд ч итгэлийн хамт олон хамтдаа мэдэрч хуваалцдаг зүйл юм. Мэдээж Ариун Зоогийн ёслол нь оролцож буй хувь хүмүүст гүн утгатай ч, энэ нь хувийн гэх ойлголтоос хавьгүй гүн утгатай.... Эзэний зоогийн ширээнд мэдэрч болох хуваалцал ба нэгдэл нь чуулганы мөн чанар болон Бурханы хүсч буй ертөнцийн загварыг харуулдаг. Ижил төстэй зарчим ТНМ-ийн төгсгөлийн хэсэгт дурдагддаг. Ариун Зоогийн ёслол нь зоогийн ширээ болон ариун амьдрал мөн хувь хүн ба хамт олон анхнаасаа холбогдсон болохыг нээн харуулах хэлбэрээр явагдана. Итгэгчид бие биетэйгээ харилцан нэг сэтгэлтэй болох нь бид нэгэн хамт олон гэх илэрхийлэл бөгөөд, цаашлаад дэлхий даяар орших чуулгануудад оршин буй христитгэгчдийн хайрын илэрхийлэл юм.

Ийм сэтгэлийг таниулдаг хоёр янзын тодорхой дохио байдаг.



Нэг дэх дохио нь: хамтдаа цугласан Бурханы хамт олон болохын хувьд, бид нэг талх нэг дарсыг хэрэглэдэг. Бидний ашигладаг Ариун Зоогийн ёслолын заавар бичээст хэлсэн байдаг шиг “Талх нэг бөгөөд олуулаа бид нэг бие учраас энэ нь бид бүгдээрээ нэг талханд оролцох юм” (1Коринт 10:17). Хоёр дахь дохио нь: бид нар өөрсдөө Ариун Зоогийг хүртэх бус, ариун зориулалтын төлөө хамт олноороо залбирч тусгаарлан бэлдсэн талх ба дарсыг өөр хүний гараар дамжуулан хүлээн авах явдал юм.

Иймэрхүү зарчим болон үзэл бодлыг дагавал бид интернет чуулганд “ирц” – ээ бүртгүүлж тэрхүү чуулганыхаа итгэгчидтэй харилцаатай байна гэх мэдрэмжийг авч болох ч, бие махбодын хувьд тусгаарлагдмал байгаа учраас адилхан медиа хэрэглээгээр дамжуулан Ариун Зоогт оролцох боломжгүй.

Дээр өгүүлсэнчлэн чуулган нь итгэгчдэд сайнмэдээг дамжуулж чадах шинэ арга замыг нээн олоход нь туслан урамшуулдаг. Мөн ийм арга зам дунд хариуцлага өндөртэй ур чадварын хэрэглээ ч багтана. Интернетээр дамжуулан мөргөл өргөж буй хүмүүст итгэгчдийн зүгээс Ариун Зоог барихад нь залбирлаараа нэгдэхээр уригддаг явдал нь үргэлж хүлээн зөвшөөрөгддөг байсан ч 2013 онд бишоп нарын хурлаар Нэгдсэн Методист чуулганы итгэгч нь онлайнаар дамжуулан Ариун Зоог хүртэхийг хориглох шийдвэрийг гаргасан.

Тэгвэл онлайнаар дамжуулан Ариун Зоогийн ёслолд оролцдог хүмүүст тохиромжтой арга зам байна уу? Энэ нь “Ариун Зоогт оролцохыг хүсэвч бие нь өвчтэй учраас чуулганд очиж чадахгүй” хүмүүст ч хамаатай. Хамт олноороо барьж буй Ариун Зоогийн ёслолд хэрэглэгдсэн талх ба дарсыг пастор эсвэл итгэгч нарын төлөөлөгчид тэдэнд аваачиж өгөх хэрэгтэй. Хэрвээ итгэгчдээсээ хол алслагдсан газар, пастор болон итгэгчдийн төлөөлөгч очих боломжгүй тохиолдолд орон нутгийнхаа ойрхон чуулгантай холбож өгөн урамшуулах хэрэгтэй.

Асуулт: Хэрвээ Ариун Зоог хүртэх үеэр бодитоор оршдог Есүс Христийн оршихуйд итгэвэл, бид талх ба дарсыг галт тэрэгний буудал юмуу автобусны зогсоол зэрэг газарт аваачиж хүртэхийг хүссэн хүмүүст хуваан өгөх хэрэгтэй биш гэж үү?

Хариулт: Онолын хувьд тохирч байгаа хэдий ч илүү гүн бодоод үзье. Эхлээд Ариун Зоогийн ёслол дахь Христийн оршихуйн талаарх Нэгдсэн Методист Чуулганы итгэгчийн ойлголт нь Христийн оршихуй нь үнэндээ талх ба дарсаар “хязгаарлагдахгүй”. Христ бол Есүсийн нэрээр цугласан хамт олны дунд оршиж... тунхаглагдаж буй үгээр дамжуулан оршихуйгаараа ирэн, мөн хуваалцах талх ба дарсаар дамжуулан хамт байдаг. Үүний нэгэн адил Бурханы оршихуйг хүртсэн хамт олон дараах үзэл бодлоор бэхжинэ. “Бид Бурханы оршихуйг эд материал хийгээд харилцааны үндсэн дээр ойлгодог.”

Хоёрдугаарт, Ариун Зоогийн ёслол нь Библи дэх Сайн мэдээ болон номлолын тунхаглалаас ангид үйлдэгдэхгүй. Үг болон зоогийн ширээ нь бүрэн төгс өргөгдөх мөргөлийн төлөө харилцан биенээ дүүргэнэ. Эдгээр нь тусдаа салгагдах юм бол Есүс Христийн итгэлээр зөвшөөрөгдсөн Ариун Сүнс доторх бялхам амийн хүч нь суларна. Ариун Зоогийн ёслолд оролцож байгаа нь тунхаглагдсан үгэнд үзүүлж буй хариу үйлдэл бөгөөд хэдийнээ тунхаглагдсан үгэнд үргэлжид оролцож буй хэрэг юм.

Эхний хоёр төрлийн зарчмыг ажиглан харахад, Христийг өргөж буй нь (offering Christ) талх ба дарсыг дамжуулах төдийгүй цугласан хамт олон болон тэд хаана ч цугласан бай хамтдаа өргөдөг үг ба зоогийн ёслол нь хангагдаж байхыг илтгэдэг. Зөвхөн талх ба дарсыг л шинэ байрлал уруу аваачих биш, мөргөл өргөж буй бүх хүмүүсийг ч гэсэн мөн аваачих хэрэгтэй. Өөр асуултад хариулахдаа танилцуулсан шиг талх ба дарс нь “итгэгчдийн цугларалт дунд ариунаар тусгаарлагдан хуваарилагдах учиртай.” Мөн ийм зарчмууд нь Библи болон номлолоор дамжуулан үг хэр чухал болохыг хөндөж өгч байгаа бөгөөд, үг нь хуваалцах ёслолын хэрэгцээтэй хэсгийг

илэрхийлдэг.

Гуравдугаарт, тусгаарлаагүй талх ба дарсыг хуваалцах хийгээд нээлттэй Ариун Зоогийн ёслол нь ялгаатай. Ариун Зоогийн ёслол нь хэзээд урилга, гэмшил, уучлалаар эхэлдэг байхыг ТНМ – д тайлбарладаг. Эзэний зоогийн ширээнээ ирж буй хүн нь, урсгал чиглэлийн уламжлалаас үл хамааран, итгэлийн хариу үйлдлээр чуулганаар дамжуулан чуулган дотор тунхаглагдсан Христийн хайранд хариу үзүүлэн зоогийн ширээ рүү ирж байгаагаар ойлгогддог. Асуултад тусгасны адил тусгаарлаагүй талх ба дарсын хуваалцал нь хүмүүсийг Ариун Зоогийн ёслолд оролцох явдлыг боломжгүй болгодог. Энэ нь гэмшил болон итгэлийн дагуух урилгыг хөндөлсөн хааж, хүмүүсийг “итгэлийн аян ба ариуслын өсөлт” рүү урин дуудах чуулганы үүргийг цалгардуулж буй хэрэг болно.

ЗООГИЙГ УДИРДАХ БА ХУВААН ТАРААХТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТ

Асуулт: Би хөдөөгийн чуулганд үйлчлэхээр зөвшөөрөл авсан сайнмэдээ тараагч (certified lay minister) байна. Ариун Зоогтой Эзэний өдрөөр хэрэглэх талх ба дарсыг ариусгаж өгөөч хэмээн пасторын холбооны тэргүүн болон жинхэнэ гишүүн болсон ахлагч пастор⁴ аас хүсэмжилж болох уу? Тэд утсаар ч юмуу скайпиар дамжуулан ариусгаж өгч чадах болов уу?

Хариулт: ТНМ нь энэхүү асуултад маш тодорхой хариултыг өгч байна: Ямар хэлбэрээр ариусган тусгаарлаж байгаагаас үл хамааран (утсаар, скайпи, фейстайм, эсвэл өөр бусад холбооны хэрэгслээр), “Талх ба дарсыг урьдаас ариусгах нь Ариун

⁴ Тосолгоо авсан пастор хүн багаар бодоход гурван жилийн туршид пасторын тосолгоогоо хамгаалан тодорхой шалгуур хийгээд библийн шалгалтыг өгсөнөөр жинхэнэ гишүүнчлэлд хамрагддаг. Ийнхүү хамгаалсан пасторыг жинхэнэ гишүүнд багтсан пастор гэж хэлдэг.

Зоогийн ёслол дээр Бурханы ивээл хэрхэн бидэнд өгөгддөг талаарх бидний түүхэн зарчим болон ойлголтод харшилдаг бөгөөд тохиромжгүй юм (Article XVIII, The Article of Religion, 64-р нүүр).”

Дээрх санаанд зовниж буй нь Агуу Талархалд юу юунаас илүү чухал зүйл бол “ариусгал” биш, харин чуулган өөрөө Бурханд хандсан талархал ба магтаалаар Эзний зоогийн ширээнээ цуглах явдал юм. “Талх ба дарс нь итгэгчид чуулганд цугласан үед ариусгагдсаныхаа дараа, хүртэх явдал билээ”

Асуулт: Хүмүүсийн гэрт нь бэлтгэсэн талх ба дарсыг хэн ариусгаж болох вэ? Бас, онлайнаар юмуу телевиз эсвэл радио нэвтрүүлгээр явагдаж буй Ариун Зоогийн талх ба дарсыг хэн нэгэн нь ариусгаж болох уу? Жинхэнэ гишүүнчлэлд багтсан ахлагч пасторуудад л боломжтой юу, эсвэл томилогдсон тус чуулганы пастор (licensed local pastor) хийж болох уу?

Хариулт: ТНМ нь энэ асуултад маш тодорхой хариулдаг. “Тослогдоод жинхэнэ гишүүнчлэлд багтсан ахлагч пастор эсвэл методистын зарчимд үндэслэн эрх мэдэл өгөгдсөн хүн л Ариун Зоогийн ёслолыг удирдан явуулж болно.”

Гэхдээ livestreaming – р дамжуулан Ариун Зоогт оролцох тухай асуулт хариултаас харсан шиг (дээрх ярилцлагыг харахыг хүсье) телевиз юмуу радио нэвтрүүлгээр дамжуулан явагдаж



буй Ариун Зоогийн ёслол ба онлайнаар дамжуулан Ариун Зоогт оролцох явдлыг 2014 оны бишоп нарыг нэгдсэн хурлын шийдвэрээр зөвшөөрөөгүй учраас хориглогдсон юм. Тиймээс иймэрхүү зорилгоор талх ба дарсыг бэлтгэх нь зохисгүй.

Асуулт: Чуулганы маань ажилчдын дунд жинхэнэ гишүүнчлэлд бүртгэгдсэн тослогдсон үйлчлэгч пастор бий. Ариун Зоогийн ёслолд тус пасторын үүрэг гэж бий юу?

Хариулт: 2012 оны итгэлийн зарчим (товхимол 328) - аас харвал жинхэнэ гишүүнчлэлд бүртгэгдсэн тослогдсон үйлчлэгч пастор нь Ариун Зоогийг удирдан явуулж буй жинхэнэ гишүүнчлэлд бүртгэгдсэн тослогдсон ахлагч пасторыг дэмжихээр заагдсан байдаг. ТНМ нь энэхүү журмыг илүү тодорхойгоор ийнхүү тайлбарласан байна. “Түүхэн болон урсгал чиглэлийн үзэл хандлагыг даган... Ариун Зоогийн ёслолд тослогдсон үйлчлэгч пасторын үүрэг нь дараахтай адил болно. Библи уншлага, дэлхий хийгээд чуулган, мөн ядуу хүмүүсийн төлөөх үйлчлэл ба залбирлыг удирдах, Агуу Талархалын өмнө талх ба дарсыг авч зоогийн ширээг бэлтгэх, Ариун Зоогийн талх ба дарсыг хуваан өгч буй тослогдсон ахлагч пасторт туслах, журмын дагуу зоогийн ширээг бэлтгэх, ахлагч пасторыг ерөөлийн залбирал хийхээс өмнө туслаж буй хүмүүсийг удирдах” “Гайхамшиг дотор амьдрах” (“Living into the Mystery”)–д Эзэний Зоогийн ширээнээ тослогдсон үйлчлэгч пасторын хийх зүйлийн талаар илүү тодорхой тайлбарласан: “жинхэнэ гишүүнчлэлд бүртгэгдсэн тослогдсон үйлчлэгч пастор нь талх ба дарсыг аваад Эзэний зоогийн ширээнээ зөв зохистойгоор тавина. Мөн, Ариун дагшинд дарсыг аягалж болох ба, дараа нь Агуу Талархлыг эхлэхээс өмнө бүх зүйлс болон бүх хүн бэлэн болсон эсэхийг нягтална. Хэрвээ талх ба дарс бүтээлтэй чигээрээ Эзэний Зоогийн ширээнээ тавиастан байвал үйлчлэгч пастор нь Ариун Зоогийн гишүүдэд зааварчлах эсвэл тэдний хамтаар бүтээлгийг авна. Энэ үед пасторын үйл хөдлөл нь ёслолд нийцсэн хирнээ энгийн мөн ивээлтэй бас хүчтэй байх хэрэгтэй. Хуулан авсан бүтээлгийг ширээн дээр эвхэж тавина.”

Асуулт: Манай чуулганд хоёр пастор байдаг. Тэр хоёр Ариун Зоогийн ёслол дээр үүргээ хуваалцахыг хүсдэг. Тэд хэрхэн үүргээ хуваалцах вэ?

Хариулт: ТНМ нь энэ асуултад тодорхой хариултыг өгдөггүй ч, бидэнд мэдэж болох санааг өгдөг. Нэгдүгээрт, Агуу Талархал нь удирдагч ба итгэгчид хамтдаа явуулах залбирал (бурханлаг үгнүүдийн “цуглуулга” гэхээсээ илүү) гэдгийг санах хэрэгтэй. Тиймээс олон удирдагч нь залбиралаа хуваалцахдаа хамтын залбирлын зан чанарыг хүндэтгэх хэрэгтэй. Мөн залбирал удирдах үйлчлэлийг хуваахдаа тухайн өдрийн залбирлын өнгө аясыг хадгалж өгөх хэрэгтэй. Цаашлаад Агуу Талархлын залбирлын аль ч хэсэгт жинхэнэ гишүүнчлэлд бүртгэгдсэн тослогдсон үйлчлэгч юмуу жирийн итгэгч үйлчлэгчид хариуцуулах хэсэг гэж байдаггүй. ТНМ – ийн дурдсанаар, “бүх итгэгчид идэвхитэйгээр оролцдог Агуу Талархлын залбирал нь тослогдсон ахлагч пастор юмуу эрх мэдлийг хүлээн авсан пастор л итгэгчдийг удирдана.” Хоёрдугаарт, ТНМ -д зааснаар, “Ариун Зоогийн ёслолд оролцож буй тослогдсон бүх ахлагч пастор болон үйлчлэгч пастор нь хамтдаа зогсож, удирдагч пасторт туслан талх ба дарсыг хуваан өгөхөд туслана.” ТНМ нь хэд хэдэн ахлагч пасторууд байх тохиолдолд Ариун Зоогийн ёслолыг нэг ахлагч пастор удирдан явуулахыг санал болгодог.

Эцэст нь нэг дэх хариултад хоёр ахлагч пастор байгаа тохиолдолд үүргээ ээлжлэн Ариун Зоогийн ёслолыг удирдахыг санал болгодог. Ингэж хэрэгжүүлснээрээ бүх ахлагч нь “Тэргүүн пастор” ч бай “туслах пастор” ч бай, мөн эрэгтэй ч бай эмэгтэй ч бай, тэдний байр сууриас үл хамааран чуулганы Ариун ёслолын үйлчлэлд адил эрх мэдэлтэй болохыг итгэгчдэд маш тодорхойгоор мэдүүлэх сайн талтай. Энэ нь мөн итгэгчид хоёр ахлагч пасторын харилцан адилгүй дуу хоолой болон харилцан адилгүй залбирлын илэрхийлэл (embodying)-ийг мэдрэх боломжийг өгдөг.

Хоёр дахь хариултаас харвал, хоёр ахлагч пастор нь тухайн өдөр Агуу Талархалын өдөр байвал теологийн үүднээсээ талархалын өдөрт хараагаа хандуулж, мөн Агуу Талархлын

хэсгийг хоёр хүн хуваан хөглөн явуулах үед теологийн үүднээс агуулгыг гажуудуулахгүй байхыг хүсдэг. Мөн, урьдчилан сайн давтаад залбирахдаа ямарваа нэгэн хэлбэржсэн зүйлгүйгээр залбирах хэрэгтэй. Жишээлбэл, Ариун Зоогийн асуулт I 89-р нүүрт буй Агуу Талархлыг ашиглах тохиолдолд, доорхтой адил үүргийг хуваарилж болно.

Пастор 1: Агуу Талархлыг эхлүүлэн “Амин амьсгалыг үлээн оруулж өгсөн.” хүртэлх хэсгийг өгүүлнэ.

Пастор 2: “Бид Бурхан уруу эргэн зогсоод... эш үзүүлэгчдээр дамжуулан бидэнд үгээ өгсөн.”

Пастор 1,2: “Тиймээс бид газар дээрх хүмүүстэй...”

Бүгд: “Ариун, ариун, ариун...”

Пастор 1: “Бурхан ариун... Эзэний тааламжит жилийг тунхагласан.”

Пастор 2: “Эзэн өвчтэй нэгнийг эдгээж... Эзэний үг болон Ариун Сүнсний хүч дотор.. амлалтыг өгсөн.”

Пастор 1: “Есүс баривчлагдсан тэр шөнө... Намайг дурсаарай хэмээгээд”

Пастор 2: “Хооллосны дараа... Намайг дурсан үүнийг үйлд хэмээсэн.”

Пастор 1: “Тиймээс бид Христээр дамжуулан биелэгдсэн... авралын гайхамшгийг өчин талархал ба магтаалыг өргөцгөөе.”

Бүгд: “Христ нас барсан...”

Пастор 1: “Энд цугласан бидэн дээр Ариун Сүнсээ цугтан... цусаар авралыг авч... Христийн бие болгож өгөөч.”

Пастор 2: “Ариун Сүнсээр... тэнгэрийн улс дахь найрын баяр хөөрт оролцуулж өгөөч.”

Пастор 1,2: “Таны Хүү Есүс Христээр дамжуулан...”

Бүгд : “Амен.”

Энэ мэтчилэн Агуу Талархалын хэсгийг хуваалцан удирдан явуулахдаа хоёр ахлагч пастор нь урьдаас анхааралтайгаар дасгал хийж үзээд үүргээ солих хэсэг болон залбиралд тохирох үйлдлээ болж өгвөл ижил байлгах хэрэгтэй.

ТАЛХ БА ДАРСНЫ ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД

Асуулт: Ариун Зоогийн ёслолд оролцох боломжгүй байсан хүмүүст хэзээ ариусган тусгаарласан талх ба дарсыг авч очих вэ? Тэр долоо хоногтоо авч очвол зүгээр үү? Тухайн сардаа багтаад сарын сүүлчээр аваачиж өгч болох уу? Талх ба дарсыг илүү удаан хадгалахын тулд тэдгээрийг хөргөгчинд хадгалж болох уу?

Хариулт: ТНМ нь уг асуултад тодорхой хариултыг өгдөггүй ч, дараахтай адил үндсэн зарчмыг танилцуулдаг. “Эзэний зоогийн ширээ нь нас, өвчин, эсвэл үүнтэй төстэй шалтгаанаар Ариун Зоогийн ёслолд оролцох боломжгүй байсан хүмүүсийн төлөө хугацааг тохиромжтойгоор сунгаж болно.” Энэхүү зарчмын хэлж буй зүйл нь Ариун Зоогийн ёслолд оролцох боломжгүй байсан хүмүүст талх ба дарсыг авч очих нь, тэрхүү Ариун Зоогийн ёслолын төлөө цугласан хамт олны Ариун Зоог нь уртасгагдсан гэсэн үг. Үүнд Ариун Зоогийн “хойшлуулсан” хэлбэр эсвэл “үлдсэн” талх ба дарс гэсэн үүднээс хандахгүй. Бидний хуваалцаж байгаа зүйл бол зөвхөн талх ба дарс биш ба Христийн дотор харилцан бие биенээсээ авдаг дотносол билээ. Эзэний зоогийн ширээнээ цугласан хамт олныхоо хувьд бидний дурсан тэмдэглэдэг зүйл бол энэхүү дотносол юм. Тэгээд бид энэхүү дотнослыг үгүйсгэж буй хэрэг биш, Ариун Зоогт оролцож чадаагүй хүмүүст зориулан сунгаж байгаа явдал юм.

Бодит байдал дээр талх нь муудаж, дарс нь исдэг гэдгийг бодолцож, бид Ариун Зоогт оролцож чадаагүй хүмүүст талх ба дарсыг тэр өдөртөө эсвэл дараа өдөрт нь багтаан авчиж өгөх хэрэгтэй. Тэрнээс илүү хоног өнгөрвөл бидний хуваалцах гэсэн дотнослын утга нь алдагдана. Иймд цаг хугацаа боломжгүй үед, пастор нь тэр хүний төлөө Ариун Зоогийн ёслолыг үйлдэхийн тулд гэрт нь хувьчлан эргэн очих хуваарийг гаргах хэрэгтэй (энэ үйлчлэлтэй холбоотой илүү

нарийн тайлбар нь “Ашигласан номын жагсаалт”-д байгаа Mark Stamm ын бичсэн Extending the Table-ыг лавлаж үзэхийг хүсье).

Асуулт: Ариун Зоогийг хүртсэний дараа үлдсэн талх ба дарсыг зохистойгоор “дуусгах” ямар арга зам байна вэ?

Хариулт: ТНМ нь Ариун Зоогоос үлдсэн талх ба дарсыг хэрхэхийг шийдэх үндсэн зарчмыг ингэж тайлбарласан: “ариусган тусгаарласан талх ба дарс нь Агуу Талархалд дурдсаны дагуу бидний төлөөх Христийн бие ба цус болсон Бурханы бүтээл бэлэг болохын хувьд хүндлэл ба талархалтайгаар хандах учиртай (УМН; 10-р нүүр). “The Book of Worship” (30-р нүүр)-т бүр цаашлаад энэ талаар ийнхүү дурдсан: “Үлдсэн талх ба дарсыг хэрхэхийг шийдэхэд Бурханы бэлгийн талаарх даамлын ухамсар болон талх ба дарсыг хүртсэн ариун зорилгыг өөрийн хандлагаар илэрхийлэх.”

Нэн тэргүүний зүйлстэй холбоотой дарааллын хувьд дараах утгыг илэрхийлнэ: Нэгдүгээрт, үлдсэн талх ба дарсыг ариун эд зүйлсийг хадгалах өрөө рүү буцаана. Тэнд үйлчлэгч пасторын хамтаар Ариун Зоогт оролцогчид нь өвдсөн хүмүүст болон оролцохыг хүссэн ч оролцож чадаагүй хүмүүсийн төлөө энэхүү талх ба дарсыг бэлтгэнэ.

Хоёрдугаарт, эдгээр нь хүнсний бэлэг учраас, “пастор болон/эсвэл пасторын зааврыг дагасан хүмүүс Ариун Зоогийн дараа чин сүсэгт хандлагаар үлдсэнийг нь иднэ.”

Эцэст нь, талх ба дарсыг “газарт асгах юмуу, газрыг ухаад булах, эсвэл цацах, шатаах зэргээр байгальд нь буцааж болох юм.” Тэдгээрийг бохирын шугам уруу асгах юмуу хогийн саванд хийж болохгүй. “Гайхамшиг дотор амьдрах нь” (Living into the Mystery) номд дараах хариултыг өгсөн: “Талх ба дарсны нэг хэсгийг шууд газарт нь буцааж буй нь экологийн

хувьд чухал гэрчлэл юм. Тэр мөчид хэрэглэгдэхгүйгээр газар уруу буцаагдсан талх ба дарс нь харьцангуй бага хэмжээнийнх байдаг. Чуулганы ногоон байгууламж юмуу цэцгийн мандалд их хэмжээний талх тарсан байх нь сайшаалтай төрх биш төдийгүй үрэлгэн байдлын дохио болно. Ариун Зоог барихдаа талх ба дарсаа хэрэглэх хэмжээгээр л бэлтгэвэл ийм үрэлгэн байдлаас зайлхийж чадна.”

Асуулт: Манай чуулганы залуучуудын бүлэг кемпэд гараад хамтдаа Ариун Зоогийн ёслолыг үйлддэг. Талх ба дарсны онрд жимс, хайрсан боорцгыг ашиглаж болох уу?

Хариулт: Онцлог соёл бүхий нөхцөлд (онцгой үед) талх ба дарсыг өөр зүйлээр орлуулж болох ч, чуулганы тогтоосон хүрэн дотор л байх ёстой. ТНМ нь бидний талх ба дарсны хэрэглэнд тусгагддаг “даяар чуулганы түүхэн үргэлжлэх чанар”-ыг чухалчилдаг. Талхны тухайд ТНМ – д ингэж өгүүлдэг. “Христийн үг ба Христитгэлийн уламжлалыг даган Ариун Зоогийн ёслолыг үйлдэхдээ чуулган нь талх (bread)-ыг хэрэглэнэ.” Үнэхээр тус үгийн илэрхийлж буй бүхэл талх нь “болж өгвөл ямар нэг тариа будаагаар хийгдсэн, тус зүйл нь талх шиг харагдаж талхны амттай байна” гэсэн утгатай. Энэ нь исгэгч ашигласан ч, ашиглаагүй ч “цэвэр талх (хатаасан үзэм, хатаасан усан үзэм, хиймэл бодис, эсвэл өөр хольц ороогүй)” байна. ТНМ нь усан үзмийн дарсны тухайд ч гэсэн төстэй зарчмыг танилцуулдаг: “Библи ба Христитгэлийн уламжлалаар бол, бүх л нийтлэг чуулган нь Ариун Зоогийн ёслолыг үйлдэхдээ усан үзмийн дарсыг хэрэглэнэ.” Протестант болон католик олон чуулганууд үргэлж л усан үзмийн дарсыг хэрэглэж байсан. Нөгөө талаас Нэгдсэн Методист чуулган нь 19-р зуунаас эхлэн бүрэн боловсорсон исгээгүй усан үзмийн дарсыг хэрэглэсээр байна.

АРИУН ЗООГИЙН СҮНСЛЭГ ЧАНАР

Нэгдсэн Методист чуулганы итгэгчдийн хувьд Ариун Зоогийн утга учир нь юу юм бол? Бид Эзэний зоогийн ширээнээ талархал ба дурсамжийн үгийг бий болгодог. Мөн тэнд Бурханыг болон хөршөө хайрла гэсэн тушаалын биелэлийг мэдэрдэг. Бид өөрт минь хандсан Бурханы хайрыг үргэлж мэдрэх боломжтой, тэр дундаа бид тийм хайрыг авах эрхгүй ч юмуу, тийм эрх байхгүй гэж мэдрэгдэх үед ч гэсэн. Эзэний зоогийн ширээнээ оролцож, талархал өргөн Ариун Зоогийг хамтдаа хуваалцахдаа, өнөөдөр бид юугаар бас хэнээс дуудлага авснаа мөн эцсийн үед бидний амьдрал яах вэ гэсэн төсөөллийг авдаг. Бид энэхүү Ариун хүнсийг Ариун Зоог, Эзэний Зоог, эсвэл Ариун Зоогийн ямар ч нэрээр нэрлэсэн бай, тэр дунд бид Бурхан шинээр бүтээнэ гэсэн амлалтыг авдаг. Бид дагалдагчийн амьдралаар амьдрахын тулд шим тэжээлээр хангагдаж Ариун Сүнсний хүчийг авч ертөнц дэх авралын зар болон үйлчлэлийн төлөө илгээгддэг.



HOM ЗУЎ

Eucharist : Christ's Feast With the Church, by Laurence Hull Stookey
(Nashville : Abingdon Press, 1993)

Let Every Soul Be Jesus' Guest, by Mark Stamm (Nashville : Abingdon,
2006)

Living into the Mystery : A United Methodist Guide for Celebrating Holy
Communion (Nashville : General Board of Discipleship, 2007)

The Worship Resources of the United Methodist Hymnal, by Hoyt
Hickman (Nashville : Abingdon, 1989)

This Holy Mystery: A United Methodist Understanding of Holy
Communion (Nashville : General Board of Discipleship, 2004)

This Holy Mystery: A United Methodist Understanding of Holy
Communion Study Guide, by Gayle Carlton Felton (Nashville : General
Board of Discipleship, 2005)

This Holy Mystery: A United Methodist Understanding of Holy
Communion Study Guide for Children, by Carolyn Tanner (Akron : OSL
Publications, 2006)

“The Duty of Constant Communion,” by John Wesley, in The Works of

John Wesley, Volume 3, edited by Albert C. Outler (Nashville : Abingdon Press, 1986) pages 427-39

“The Means of Grace,” by John Wesley, in The Works of John Wesley, Volume 1, edited by Albert C. Outler (Nashville : Abingdon Press, 1984) pages 376-97

Worshiping With United Methodists : A Guide for Pastors and Church Leaders, by Hoyt L. Hickman (Nashville : Abingdon Press, 1996)

Worship Matters (Volumes 1 and 2), edited by E.Byron Anderson (Nashville : Discipleship Resources 1999)

ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Rev. Dr. E. Byron (Ron) Anderson нь Garrett-Evangelical Theological Seminary (Evanston, Illinois) – д мөргөл судлалын багшаар ажилладаг. Anderson доктор нь Минэсутад харьяалагддаг Нэгдсэн Методист чуулганы пастор юм.